



Монголын Эмэгтэйчүүдийн Сан

GLOBAL FUND FOR
WOMEN
Champions for Equality.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДАВХИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ **ГАРЫН АВЛАГА**

(MOVEMENT CAPACITY ASSESSMENT TOOL)

Улаанбаатар
2020 он

Хөдөлгөөний чадавхийн үнэлгээний гарын авлагыг боловсруулах, аргачлалыг ашиглан Дорнод аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлын төлөөх нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх хөдөлгөөн”-д үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд суурилан хөдөлгөөний чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Дэлхийн эмэгтэйчүүдийн санд талархлаа илэрхийлж байна.



Бидэнтэй холбогдоорй
+976 7711 9991



Мэдээлэл аваарай
Mongolianwomensfund.mn



Бидэнтэй нэгдээрэй
FemPhilanthropist



Бидэнтэй нэгдээрэй
Mongolian Women's Fund



Биднийг дагаарай
MONES2000



Бидэнтэй нэгдээрэй
MONES2000

АГУУЛГА

Өмнөх үг	4
ГАРЫН АВЛАГЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?	6
Хөдөлгөөний чадавхийн үнэлгээний аргачлал гэж юу вэ?	6
Бид нийгмийн хөдөлгөөн гэдгийг хэрхэн ойлгох вэ?	6
Аргачлалыг хэрхэн ашиглах вэ?	8
Хөдөлгөөний үнэлгээг зохион байгуулагчдад зориулсан зааварчилгаа	9
ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ	14
ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ	24
Үнэлгээг зохион байгуулах алхмууд	24
Хавсралт А: Хөдөлгөөний чадавхийг бэхжүүлэх аргачлалын ажлын хүснэгт	27
Хавсралт В: Интерактив зураглал болон тараах материал	32
ДОРНОД АЙМГИЙН “ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨХ НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА” ХӨДӨЛГӨӨНИЙ ЖИШЭЭ, ҮР ДҮН	40

ӨМНӨХ ҮГ

Монголын эмэгтэйчүүдийн сан (МОНЭС) нь эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, бүлгүүдэд нийгмийн хөгжлийн төлөө санхүүгийн дэмжлэг үзүүлдэг үндэсний анхдагч сан юм. МОНЭС нь 2000 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг арилгах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, охид, залуу эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд эмэгтэйчүүдийн дасан зохицох, сааруулах чадварыг нэмэгдүүлэх, байгал орчны шударга ёсыг тогтооход эмэгтэйчүүдийн оролцоог бий болгох, хангахад эмэгтэйчүүдийн бүлэг, ТББ-уудад санхүүгийн болон мэдлэг арга зүйн дэмжлэг үзүүлж байна.

Монголын эмэгтэйчүүдийн сан нь эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг үүсгэн бий болгох, эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх, хөгжүүлэх, тэднийг дэмжихэд анхаарлаа хандуулж ирсэн юм. Эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийг арилгахын төлөөх нэгдмэл зорилготой хөдөлгөөн нь хөгжлийнхөө аль түвшинд байгаа, цаашид хөдөлгөөнийг хөгжүүлэх, бэхжүүлэх, тогтвортой байдлыг нь хангах, чадавхийг нэмэгдүүлэхэд анхаарах асуудлуудыг тодорхойлох зорилгоор хөдөлгөөний чадавхийн үнэлгээний аргачлалыг боловсруулах нь чухал байсан билээ.

Охид эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн шударга ёсны төлөөх нийгмийн хөдөлгөөнүүдийг дэмжиж ажилладаг Дэлхийн Эмэгтэйчүүдийн Сангаас (Global Fund for Women) эмэгтэйчүүдийн хөдөлгөөний чадавхийг үнэлэх аргачлал боловсруулж, 2018, 2019 онуудад Кени, Гүрж, Украин, Монгол, Испани, Мексик зургаан улсын, үндэсний хэмжээний эмэгтэйчүүдийн найман сантай хамтран туршилтын журмаар эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хамгаалах нийгмийн хөдөлгөөнүүдэд үнэлгээ хийсэн билээ. Хөдөлгөөний чадавхийн үнэлгээ нь эмэгтэйчүүдийн сангууд тэтгэлэг төслүүд болон тэтгэлэг олгох бодлогоороо дамжуулан эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, дэмжих нийгмийн хөдөлгөөнүүдийг үүсгэн бий болгоход эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх, хөдөлгөөнийг бэхжүүлэхэд санхүүжүүлэгч

байгууллагуудын үүрэг оролцоо, анхаарах зүйлс юу байх вэ гэдгийг тодорхойлж гаргахыг зорьсон юм. Дэлхийн эмэгтэйчүүдийн сан чадавхийн үнэлгээний аргачлалыг боловсруулж, хөдөлгөөнийг үнэлэхдээ дараах дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсон байна. Үүнд:

- Нэгдсэн зорилго, нэг эрх ашгийн төлөө нэгдэж хөдөлгөөний оролцогч тал, эд эс болж буй хүмүүсийн хоорондын харилцаа, үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл хэрэгцээ шаардлага, тэд нэгдсэн зорилго, чиглэлээ юу гэж ойлгож байгааг тодорхойлох;
- Оролцогч талуудын нэгдмэл байдал, нэг нэгэндээ итгэх итгэлцэл;
- Оролцогч талууд үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулан хамтын стратеги хэрэгжүүлэх боломжтой байдал;
- Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүдэд урт хугацааны ямар дэмжлэг, нөөц шаардлагатай байдаг, санхүүжүүлэгч байгууллага (ялангуяа тэтгэлэг олгогч байгууллага) юунд анхаарах, ямар арга зүй, стратегийг баримтлах зүйтэй байдаг зэргийг тодорхойлохыг зорьсон.

Бид Дэлхийн эмэгтэйчүүдийн сангийн дэмжлэгтэйгээр энэхүү аргачлалыг монголын эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүдэд зориулан, ашиглахад илүү хялбар болгон боловсруулж, энэхүү аргачлалыг ашиглан үнэлгээнд хамруулсан Дорнод аймаг дахь “Жендэрийн эрх тэгш байдлын төлөөх нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх хөдөлгөөн”-ий үр дүн, жишээг хавсаргалаа.

Энэхүү аргачлалыг боловсруулах, аргачлалын хүрээнд Дорнод аймгийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнд үнэлгээ хийхэд арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Дэлхийн эмэгтэйчүүдийн санд талархалаа илэрхийлье.

Монголын эмэгтэйчүүдийн сан

ГАРЫН АВЛАГЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Хөдөлгөөний чадавхийн үнэлгээний аргачлал гэж юу вэ?

Тогтвортой үргэлжлэх, урт хугацааны нийгмийн өөрчлөлтийг авчрахад нийгмийн хөдөлгөөнүүдийн оролцоо маш чухал байдаг. Мөн нийгмийн хөдөлгөөнд олон талын дэмжлэг үзүүлж байдаг санхүүжүүлэгч байгууллага, хүмүүс, ТББ-ууд, нийгмийн идэвхтэн, активистууд, эвсэл сүлжээ зэрэг олон талын хамтрагчдад тухайн хөдөлгөөний давуу тал, зорилго чиглэл, үйл ажиллагаа стратеги, хэрэгцээ шаардлагын талаар үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх нь хөдөлгөөн цаашдаа тогтвортой, олон талын оролцоотой болоход чухал ач холбогдолтой.

Энэхүү үнэлгээний зорилго нь хөдөлгөөний бүх оролцогч талууд хөдөлгөөнийхөө чадавхийг өөрсдөө үнэлж, тодорхойлох явдал юм. Үнэлгээний үр дүнд тулгуурлан тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэж, сайжруулах алхмуудаа хөдөлгөөний гишүүн хүн бүрийн оролцоотой тодорхойлох боломжтой юм. Түүнчлэн, хөдөлгөөний гишүүд өнөөг хүртэл хийсэн ажлынхаа үр дүн, ахиц дэвшил, амжилтаа хэмжих, цаашдын төлөвлөгөөгөө сайжруулахад анхаарах чухал асуудлуудаа системтэй, нэгдмэл нэг арга зүйгээр гаргаж ирэх боломж олгоно.

Хөдөлгөөний чадавхийн үнэлгээг энэхүү арга зүйгээр, хөдөлгөөний гишүүд өөрсдөө, хөдөлгөөний манлайлагчид, хандивлагч, санхүүжүүлэгч байгууллага эсвэл бүр тухайн асуудлаар ажиллах сонирхолтой хөдөлгөөнд огт хамааралгүй хүмүүс, байгууллага гэх мэт аль ч талын санаачилгаар хийж болох бөгөөд харин үнэлгээг удирдан зохион байгуулах нэг байгууллага эсвэл хувь хүмүүсийг томилох шаардлагатай байдаг.

Бид нийгмийн хөдөлгөөн гэдгийг хэрхэн ойлгох вэ?

Дэлхийн эмэгтэйчүүдийн сангийн тодорхойлсноор нийгмийн хөдөлгөөн гэдэг нь: Өөрчлөлтийг хамтаараа бий болгох зорилгоор нэгдсэн, нэгдмэл нэг зорилготой хүмүүсийн нэгдэл юм.

Хөдөлгөөн нь хүчтэй манлайлагчдын төлөөлөл, олон нийтийн дэмжлэг, нягт хамтын ажиллагаа, ирээдүйд улс төр, нийгмийн өөрчлөлт бий болгох нэгдсэн зорилго, төлөвлөгөө зэргээс бүрдэнэ.

Хөдөлгөөн нь нөлөөллийн ажил, хэвлэлийн мэдээллийн хэрэгслийг ашиглах аргачлал,

хууль эрх зүйн арга хэмжээ, эсэргүүцлийн арга хэмжээ, судалгаа шинжилгээ гэх мэт стратегиудыг өргөн ашигладаг.

Мөн, судлаач эрдэмтэн, феминист, эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалагч Шрилата Батливала хөдөлгөөнийг дараах байдлаар тодорхойлсон байна (2008):

“Нийтлэг-тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх замаар одоогийн нөхцөл байдлыг өөрчлөх зорилго бүхий нэгдсэн зохион байгуулалтад орсон хүмүүсийн хамтын үйл ажиллагааны нэгдэл юм.”

Бид энэхүү гарын авлагад нийгмийн хөдөлгөөний дээрх хоёр тодорхойлолтын хүрээнд авч үзлээ.

Хөдөлгөөний чадавхийн үнэлгээний энэхүү арга зүйн хүрээнд бид нийгмийн хөдөлгөөн нь дараах нийтлэг, онцлог шинж чанартай байдаг гэж үзсэн. Үүнд:

1. Орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг;
2. Ил тод, системчлэгдсэн манлайллын тогтолцоотой;
3. Нэг нэгэндээ хүчтэй хамтрагч нь болж байдаг;
4. Хамтаараа нийтлэг - тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд чиглэсэн;
5. Хэд хэдэн стратегийг буюу үйл ажиллагаа, аргачлалыг нэгэн зэрэг эсвэл шат дараалан хэрэгжүүлдэг;
6. Байгууллага эсвэл системийн суурь, үндсэн бүтцийг дэмжиж байдаг;
7. Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадвар сайн гэсэн шинж чанарууд байдаг байна.

Түүнчлэн, нийгмийн хөдөлгөөний хөгжлийн үе шатыг: (a) үүсэн бий болж буй, (b) бүрэлдэн тогтож буй, (c) бүрэн төлөвшсөн, (d) зогсонги байдалд орсон буюу уналтанд орсон хэмээн ангилж болно. Нийгмийн хөдөлгөөнүүд хөгжлийн аль шатандаа явж байгаагаас шалтгаалан чадавхжуулах, дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага нь ялгаатай байдаг байна.

Дээр дурдсан ойлголтуудын талаарх оролцогч талуудын ойлголт, үзэл хандлагыг хэмжиж, үнэлснээр нийгмийн хөдөлгөөний өмнө тулгараад байгаа бэрхшээл, өөрсдийн давуу талыг тодорхойлж, нэн тэргүүний шийдвэрлэх шаардлагатай мөн нэгдсэн зорилгоо хамтаараа бий болгох ач холбогдолтой юм.

Аргачлалыг хэрхэн ашиглах вэ?


Хөдөлгөөний чадавхийг үнэлэх энэхүү аргачлалыг ашигласнаар бид оролцогч талууд өөрсдийн хөдөлгөөнийг юу гэж ойлгодог, ямар сэтгэгдэлтэй байдаг, ямар давуу сул талтай, ямар бэрхшээлтэй асуудлууд байдаг гэж бодож явдаг талаар цогц мэдээлэлтэй болох юм.

Энэхүү үнэлгээгээр гарсан үр дүн нь зөв эсвэл буруу гэсэн ойлголт байхгүй бөгөөд орон нутгийн онцлог ялгаатай, нөхцөл байдлаас шууд хамааралтай тул, бидний зүгээс, үнэлгээний үр дүнг асуудлаа хэлэлцэх, тодорхойлох, нэгдсэн ойлголттой болох эхний алхам болгох зорилгоор ашиглахыг зөвлөж байна.

Хөдөлгөөний чадавхийг үнэлэх аргачлал нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Хөдөлгөөний долоон онцлог шинж чанар
- Давуу тал, бэрхшээл, нэн тэргүүний асуудлууд
- Хөдөлгөөний үе шат
- Хөдөлгөөн доторх үүрэг оролцоо

Үнэлгээний үйл явц нь дор дурдсан 5 үндсэн алхамтай байна:



Үнэлгээг зохион байгуулагч байгууллага нь үнэлгээнд оролцох байгууллагыг сонгож, оролцогч талуудыг үнэлгээнд урьж оролцуулан, үр дүнг нэгтгэн, оролцогчдод танилцуулна.

Хөдөлгөөний үнэлгээ хийх зохион байгуулагчдад зориулсан заавар

Дээр тэмдэглэсний дагуу энэхүү аргачлалыг ашиглан сонгосон нэг хөдөлгөөний чадавхийг үнэлэх үнэлгээг зохион байгуулах байгууллага сонгоно.

Энэхүү гарын авлагыг уншиж буй та, танай байгууллага эсвэл хөдөлгөөн дотроо ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилгүй, бусад оролцогч талуудаа зохион байгуулалтад оруулах чадвартай хөдөлгөөний аль нэг гишүүн, оролцогч тал ч үнэлгээг удирдан зохион байгуулж болно.

Үнэлгээг зохион байгуулагч нь дор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

- 1.1 Энэхүү аргачлал нь таньд зориулагдсан эсэхийг шалгаж, баталгаажуулна
- 1.2 Үнэлгээнд хамрагдах хөдөлгөөнөө тодорхойлно
- 1.3 Үнэлгээнд оролцох хөдөлгөөний оролцогч талуудыг урьж оролцуулна
- 1.4 Мэдээлэл цуглуулах ажилд дэмжлэг үзүүлнэ
- 1.5 Үнэлгээний үр дүнг нэгтгэж оролцогчдод танилцуулна. Үр дүнд тулгуурлан дараагийн алхамуудаа ярилцах хэлэлцүүлгийг удирдан зохион байгуулна.

1.1 Энэхүү аргачлал нь таньд зориулагдсан эсэхийг шалгаж, баталгаажуулна.

Үнэлгээнд хамруулах хөдөлгөөнөө дараах шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг тодорхойлсны үндсэн дээр сонгоно:

- Тухайн хөдөлгөөн нь нийтлэг-тулгамдсан асуудлуудаа хамтын, нэгдмэл үйл ажиллагаатайгаар шийдвэрлэх замаар одоогийн нөхцөл байдлыг өөрчлөх зорилготой нэгдэж, зохион байгуулалтад орсон хувь хүмүүс, байгууллагуудаас бүрдсэн байна.
- Эдгээр хувь хүмүүс, байгууллагууд нь тухайн хөдөлгөөнийг байдаг гэдгийг мөн үйл ажиллагааг нь мэддэг төдийгүй өөрсдийгөө хөдөлгөөний нэг хэсэг гэж үздэг.
- Эдгээр хувь хүмүүс, байгууллагууд энэхүү үнэлгээнд хамрагдсанаар гарах үр өгөөж нь боломжит эрсдэлээс өндөр байх.
- Зохион байгуулагч байгууллагын хувьд, та эсвэл танай байгууллага үнэлгээнд хамрагдах хөдөлгөөний оролцогч талуудтай холбоо харилцаа тогтоох боломжтой байх

Дор дурдсан нөхцөлүүдэд энэхүү аргачлалыг АШИГЛАХГҮЙ:

- Та эсвэл танай байгууллага сүлжээ, эвсэл, компанит ажил эсвэл байгууллагыг үнэлэхээр зорьж байгаа (сүлжээ, эвсэл, компанит ажил, байгууллагыг үнэлэхэд зориулсан өөр олон аргачлалууд байдаг)
- Хөдөлгөөний оролцогч тал гэж үзэн үнэлгээнд хамруулахаар сонгосон хувь хүмүүс, байгууллагуудын зүгээс өөрсдийгөө хөдөлгөөний нэг хэсэг гэж үздэггүй (өөрсдийн үйл ажиллагааг тухайн үнэлгээнд хамрагдаж буй хөдөлгөөний үйл ажиллагаатай холбож үзэхгүй байх, хөдөлгөөний нэгдсэн зорилгын талаар мэдэхгүй, ойлголтгүй байх)
- Хувь хүн, байгууллагууд энэхүү үнэлгээнд хамрагдсанаар тулгарч болох боломжит аюул, эрсдэл нь үнэлгээ хийх үр өгөөжөөс илүү хор хохиролтой байх.
- Үнэлгээнд хамрагдах хөдөлгөөний оролцогч талууд, гишүүдтэй харилцаа холбоо тогтоох, холбогдох боломж хязгаарлагдмал байх.

1.2 Үнэлгээнд хамрагдах хөдөлгөөнөө тодорхойлно:

Үнэлгээнд хамруулахаар сонгосон хөдөлгөөнийг **тодорхойлсон тодорхойлолт нь маш нарийн, тодорхой байх тусмаа илүү үр дүнтэй байна.**

Үнэлгээг эхлүүлэхдээ **тухайн хөдөлгөөний талаар тодорхой, ойлгомжтой мэдээлэл өгөх нь оролцогчид нэг зүйлийн төлөө явж байгаа гэдгээ илүү сайн ойлгож, илүү бодитой, хэрэгцээтэй үр дүнг** бий болгох боломжтой болно. Иймд үнэлгээнд хамруулах нийгмийн хөдөлгөөнийг тодорхой асуудлаар нь, хүн амаар, зорилгоор нь эсвэл тодорхой нэг бүс нутгийг хамарсан байдлаар тодорхойлох нь оновчтой байдаг. Жишээлбэл, Улаанбаатар хотын утааны эсрэг хөдөлгөөн байж болно. Энэ жишээнээс харахад газар зүйн байршил, сонгосон асуудал зэрэг нь тодорхой байгаа тул оролцогчид өөр бусад хөдөлгөөнтэй андуурч ойлгохгүй.

Нийгмийн хөдөлгөөнүүд нь байнга өөрчлөгдөн, хувьсаж байдаг, албан ёсны бүтэц, гишүүнчлэлгүй зэргээс шалтгаалан хөдөлгөөнийг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг. Гэсэн хэдий ч үнэлгээнд оролцогчид тухайн сонгож авсан хөдөлгөөний талаарх үнэлгээ гэдгийг бататгахын тулд зохион байгуулагчийн зүгээс тухайн хөдөлгөөнийг аль болох тодорхой дүрслэх нь чухал юм. Хөдөлгөөний оролцогч талууд, гишүүд хэд хэдэн хөдөлгөөний үйл ажиллагаанд зэрэг оролцдог байж болно. Тиймээс

үнэлгээнд хамрагдаж буй хөдөлгөөнийг нарийн сайн тодорхойлох нь оролцогчид аль хөдөлгөөнийг үнэлж байгаа талаар мэдээлэл, ойлголтоор болж, үл ойлголцол, эргэлзээ үүсэхгүй юм.

Үнэлгээ хийж эхлэхийн өмнө хөдөлгөөний оролцогч талуудтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна.

- Үнэлгээг зохион байгуулагчид, хөдөлгөөний оролцогч талуудтай уулзаж, тухайн хөдөлгөөнийг гишүүд, оролцогчид нь хэрхэн тодорхойлж буй талаар ойлголт, мэдээлэл өгнө. Хөдөлгөөний талаарх ойлголт, тодорхойлолт нь хөдөлгөөний гишүүн, оролцогч бүрийн хувьд харилцан адилгүй байж болно.

1.3 Хөдөлгөөний оролцогч талуудыг урьж оролцуулах

Олон талын төлөөллийг багтаасан байх

Нийгмийн хөдөлгөөнүүд нийгмийн олон бүлгийн төлөөллөөс бүрдэж байдаг тул үнэлгээг зохион байгуулагч байгууллагын зүгээс үнэлгээндээ аль болох ялгаатай үзэл, хандлагатай, хөдөлгөөн дотроо ч мөн өөр өөр үүрэг, оролцоотой байгууллага, хувь хүмүүсийг урьж оролцуулахад анхаарах нь зүйтэй юм. Үүнд:

- Хөдөлгөөний манлайлагчид;
- Олон нийт иргэдтэй тулж ажилладаг байгууллагууд (grassroots);
- Иргэний нийгмийн байгууллагууд, идэвхтэн активистууд, ТББ-ууд;
- Судлаач, эрдэмтэд, хөдөлгөөний мэргэжилтнүүд;
- Хандивлагчид буюу санхүүжүүлэгчид;
- Орхигдсон бүлгийн төлөөлөл;
- Бусад хөдөлгөөний үйл ажиллагаанд давхар оролцдог хүмүүс, байгууллага;
- Үнэлгээнд хамрагдаж буй тухайн хөдөлгөөний шийдвэрлэхээр зорьсон асуудалд хамгийн их өртөөд байгаа хүн амын төлөөлөл, тэдний өөрсдөө удирддаг байгууллага, бүлэг;
- Үе, үеийн (Generational difference) төлөөлөл гэсэн ойлголтонд ахимаг настнууд – залуу идэвхтэн/активистууд; үйл ажиллагаа нь жигдэрсэн – байгуулагдаад удаагүй байгууллагууд; хөдөлгөөний үйл ажиллагаанд олон жил оролцсон – шинэ гишүүд дэмжигчид гэх мэт төлөөллийн оролцоог хангахад анхаарна.

Хөдөлгөөний хэмжээ, цар хүрээнээс шалтгаалан үнэлгээнд урьж оролцуулах оролцогчдын тоог тодорхойлно.

Бүх талуудын оролцоог хангахаас гадна үнэлгээнд хамрагдах **оролцогч талуудын тоо мөн чухал** байдаг. Хөдөлгөөний оролцогч тал, бүлэг тус бүрийн төлөөллийг оролцуулах тусам үр дүн нь илүү найдвартай, төлөөлөх чадвар өндөр болж ирнэ. Үнэлгээнд хамруулах хүний тоо нь тухайн хөдөлгөөн ямар цар хүрээтэй ажилладаг гэдгээс мөн шалтгаална. Оролцогч талууд олон байх тусам үнэлгээнд хамруулах оролцогчдын тоо нэмэгдэнэ. Үнэлгээнд хамруулах зохистой тоо хэмжээг цахимаар түүврийн хэмжээг тооцоолох хэрэгслийг ашиглах боломжтой. Үнэлгээнд хамруулахаар урьсан хүмүүсээс зарим нь л оролцох боломжтой байдаг тул зорилтот хэмжээнээсээ хамгийн багадаа 150% эсвэл 200%-аар олон оролцогчдыг урих нь зүйтэй, ингэснээр таны хүсэж буй тооны оролцогчид үнэлгээнд хамрагдана. Оролцоо нь үргэлж сайн дурын үндсэн дээр байх ёстой гэдгийг анхаарна уу.

Оролцогчдоос үнэлгээнд оролцуулах бусад оролцогч талуудын саналыг авах Олон бүлгийн төлөөлөл, хүмүүсийг хамруулахад хөдөлгөөний оролцогч талуудаас **тухайн хөдөлгөөний гишүүн байж болох, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд оролцдог, энэхүү үнэлгээнд оролцох ёстой гэж үзэж буй хамтран зүтгэгч, бусад оролцогч талуудыг санал болгохыг асуух нь** үр дүнтэй байдаг. Учир нь ихэнх тохиолдолд үнэлгээг зохион байгуулж буй байгууллага тэр бүр хөдөлгөөний бүх гишүүдийг мэддэггүй.

1.4 Мэдээлэл цуглуулах

Оролцогчдоос цахимаар мэдээлэл цуглуулах

- Үнэлгээг зохион байгуулагч байгууллага сонгож авсан хөдөлгөөний чадавхийн үнэлгээг хийхдээ аюулгүй цахим холбоосыг оролцогчдод илгээж, тэднийг үнэлгээнд урьж оролцуулна.
- Үнэлгээний асуултуудыг бөглөж дуусах хугацаа нь хамгийн багадаа хоёр долоо хоног, ихдээ дөрвөн долоо хоног байх нь зохистой бөгөөд үнэлгээг бөглөж дуусгах тодорхой хугацаа товлох нь чухал юм.
- Зохион байгуулагч байгууллага нь үнэлгээнд оролцогчдын оролцоо, бүрэн хариулт өгсөн эсэх болон ирцийг нь бүртгэн, оролцогчдыг үнэлгээнд бүрэн гүйцэд оролцоход нь хяналт тавьж ажиллана.

- Зохион байгуулагч байгууллага нь оролцогчдод энэхүү үнэлгээ нь оролцогчийн төлөөлж буй байгууллага, эвсэл сүлжээ эсвэл тухайн хөдөлгөөнд гүйцэтгэх үүрэг оролцооны талаар бус харин тухайн сонгож авсан хөдөлгөөнд чадавхийн үнэлгээ хийж байгаа гэдгийг тайлбарлана.
- Үнэлгээний асуултуудтай холбоотой нэмэлт мэдээлэл өгөх, оролцогчдод асуултуудад хариулахад дэмжлэг үзүүлнэ.

Хэрвээ та бүхэн оролцогчидтой биечлэн уулзаж үнэлгээг зохион байгуулахаар төлөвлөж байгаа бол энэ баримт бичигт хавсаргасан хэлэлцүүлгийн удирдамжийг ашиглахыг бидний зүгээс зөвлөж байна.

1.5 Үр дүнг танилцуулах, хэлэлцэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаагаа хэлэлцэх, төлөвлөх

Оролцогч талууд үнэлгээний асуултуудад бүрэн хариулж дуусмагц зохион байгуулагчийн зүгээс цуглуулсан үнэлгээний **мэдээлэлд дүн шинжилгээ хийж нэгтгэн, оролцогчдод танилцуулна.**¹

¹ Мэдээлэлд дүн шинжилгээ хийх загвар болон арга зүйн талаар мэдээлэл авах бол МОНЭС-тай холбогдоно уу

ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

1-р ХЭСЭГ: ХӨДӨЛГӨӨНӨӨ ТОДОРХОЙЛНО

1. Та өөрийн оролцсон (оролцож буй) нийгмийн хөдөлгөөнийг тухайн хөдөлгөөний газар зүйн байршил, сонгож авсан асуудал, онцлог шинж гэх мэтээр нь тодорхойлно уу (жишээлбэл, Улаанбаатар хотын утааны эсрэг хөдөлгөөн гэх мэт)

2. Та нийгмийн хөдөлгөөнийг хэрхэн тодорхойлох вэ?

3. Энэхүү судалгааны хүрээнд бид [ХӨДӨЛГӨӨНИЙ НЭРИЙГ ОРУУЛНА УУ] хөдөлгөөний талаар мэдээлэл цуглуулах зорилготой. Дараах асуултууд нь зөвхөн нэрийг дурдсан хөдөлгөөнтэй хамааралтай байх бөгөөд таны хариулт зөвхөн энэхүү хөдөлгөөнтэй хамааралтай байна.

2-р ХЭСЭГ: ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭ

“_____” хөдөлгөөний талаарх дор дурдсан мэдээллүүдийг өгөгдсөн оноог ашиглан хариулна уу. Бид танай байгууллага эсвэл хөдөлгөөн доторх танай байгууллагын үүрэг оролцооны талаар асуугаагүй бөгөөд дээр нэр дурдсан, сонгож авсан хөдөлгөөний талаарх таны үзэл бодлыг асууж байгаа гэдгийг анхаарна уу.

Танай хөдөлгөөний талаарх доорх мэдэгдлүүдтэй та хэр санал нийлж байна?

1=огтхон ч үгүй; 2=бага зэрэг; 3=тодорхой хэмжээнд; 4=боломжийн хэмжээнд; 5=маш их; 0=мэдэхгүй;

1. Хүчтэй, тогтвортой, олон талын оролцогчидтой, олон нийтэд түшиглэсэн байдал [орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг]

1.1 Энэхүү хөдөлгөөний оролцогч талууд, гишүүд нь тухайн асуудалд хамгийн их өртсөн хүн ам (жишээлбэл УБ хотын утаанаас болж эрүүл мэндээрээ хамгийн их хохирсон хүн амын төлөөлөл, хүүхдүүд гэх мэт) – олон нийтийн төлөөлөл болж чаддаг.

1.2 Энэхүү хөдөлгөөний оролцогчид нь олон талт, ялгаатай хүн ам бүлгийг төлөөлдөг.

1.3 Энэхүү хөдөлгөөнийг дэмждэг, та бүхэнтэй нэгдэн, ямар нэгэн үйлдэл хийхэд бэлэн маш олон хүмүүс бий.

1.4 Хүмүүс энэхүү хөдөлгөөнд нэгдэж орох олон боломжууд байдаг.

1.5 Хөдөлгөөний шийдвэрлэхээр зорьсон, сонгож авсан асуудалд хамгийн их өртсөн хүмүүс өөрсдийнхөө төлөө дуу хоолойгоо нэгтгэн, орон нутагтаа бусдыгаа манлайлж, энэхүү өөрчлөлтийн үйл явцыг өөриймсгөөр авч үздэг.

2. Олон талын төлөөллийг багтаасан манлайлагчид – дараагийн үеийн манлайлагчдын төлөөллийг мөн оролцуулна.

2.1 Залуу манлайлагчдын хөдөлгөөнд оруулж буй хувь нэмрийг хөдөлгөөний бусад оролцогч талууд, гишүүд хүлээн зөвшөөрдөг.

2.2 Үе, үеийн (generational) манлайлагчид өөр хоорондоо санал бодол, мэдлэг ур чадвараа хуваалцаж, хамтран ажилладаг.

2.3 Тухайн асуудалд хамгийн их өртсөн орон нутгийн манлайлагчид болон шинэ үеийн манлайлагчид гэх мэт хөдөлгөөн дотроо шинэ манлайллыг бэлтгэх, хөгжүүлэх, дэмжих тодорхой механизм байдаг.

2.4 Хөдөлгөөний манлайлагч (манлайлагчид) нь гишүүд, оролцогч талуудынхаа хэрэгцээ шаардлага, тэдний санал хүсэлтийг үргэлж нээлттэй хүлээн авч, хөдөлгөөний зорилго, хөтөлбөртөө хэрэгцээ шаардлага, эдгээр саналыг тусгаж, хэрэгжүүлж ажилладаг.

3. Хөдөлгөөн дотроо гишүүд өөр хоорондоо болон бусад хамтрагч хөдөлгөөнүүдтэйгээ маш сайн хамтран ажилладаг.	
3.1 Энэ хөдөлгөөнд багтдаг бүлгүүд хоорондоо маш нягт хамтран ажилладаг.	
3.2 Энэ хөдөлгөөнд багтдаг бүлгүүд эмэгтэйчүүдийн, өөртөө туслах, оюутнуудын гэх мэт албан бус бүлгүүдтэй (эрх зүйн тодорхой статусгүй бүлэг хүмүүсийн төлөөлөл ЭСВЭЛ жижиг болон дотроо ямарваа нэгэн албан ёсны бүтэц байхгүй бүлгүүд) холбогдож, үйл ажиллагаандаа маш идэвхтэй хамруулдаг.	
3.3 Манай хөдөлгөөний үйл ажиллагаанд бусад хамтрагч хөдөлгөөнүүд идэвхтэй оролцож, дэмжлэг тусалцаа үзүүлж байдаг.	
3.4 Энэхүү хөдөлгөөнд багтдаг бүлгүүд манай хөдөлгөөний үйл ажиллагаанаас гадна, нийгмийн шударга ёс, хүний эрхийн бусад асуудлуудаар идэвхтэй ажилладаг.	
4. Нэгдмэл зорилготойгоор улс төр, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн (хөдөлгөөн нэгдмэл зорилготой эсэх)	
4.1 Манай хөдөлгөөн маш тодорхой, урт хугацааны зорилго, алсын хараатай.	
4.2 Манай хөдөлгөөн богино хугацааны зорилго, зорилт, шийдвэрлэх асуудлуудаа маш тодорхой гаргаж ирж, тодорхойлсон.	
4.3 Тулгамдаж буй асуудлынхаа талаар нэгдмэл ойлголттой.	
4.4 Тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх боломжит шийдлүүдийн талаар нэгдмэл ойлголттой.	
4.5 Манай хөдөлгөөний гишүүд богино хугацаанд, өндөр зохион байгуулалттайгаар боломжийг маш сайн ашиглаж, хариу үйлдэл үзүүлж чаддаг.	
4.6 Манай хөдөлгөөн, хөдөлгөөн доторх болон хөдөлгөөнөөс гадуурх асуудлуудыг оновчтой томъёолж, нэг нэгэндээ мэдээлж байдаг.	
5. Бүгд нэгдсэн ойлголттойгоор хэрэгжүүлэх хэд хэдэн стратегийг ашигладаг.	
5.1 Хөдөлгөөний нэгдмэл зорилгодоо хүрэхийн тулд гишүүд, дэмжигч болох хувь хүмүүс, бүлгүүдийн зүгээс олон төрлийн стратегийг ашигладаг. Жишээлбэл, олон нийтийг зохион байгуулалтанд оруулах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, бодлогын дүн шинжилгээ, нөлөөллийн ажил, лобби, шүүхэд зарга мэдүүлэх, судалгаа гэх мэт стратегиуд байж болно.	
5.2 Хөдөлгөөний оролцогч талууд болох хувь хүмүүс, бүлгүүд, хөдөлгөөний нэгдсэн зорилгодоо хүрэхийн тулд өндөр зохион байгуулалттайгаар олон ялгаатай стратегиудыг ашигладаг.	

5.3 Стратеги боловсруулахад шаардлагатай баримт нотолгоо бий болгох зорилгоор хөдөлгөөнд нэгдсэн хувь хүмүүс, бүлгүүд нэгдсэн зохион байгуулалтанд орж хүчин чармайлт гаргадаг.	
5.4 Хөдөлгөөн өөр өөр зорилтот бүлгийн төлөөлөлтэй холбогдох, харилцаа холбоо тогтоохдоо оновчтой технологи, мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй ашиглаж чаддаг.	
6. Манай хөдөлгөөн байгууллагын бүтэц, системийг сайн дэмждэг (нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн байгууллагууд, үр дүнтэй шийдвэр гаргах тогтолцоо, харилцаа холбооны систем гэх мэт)	
6.1 Хөдөлгөөний гишүүн бүлгүүд хамтдаа цугларан, бие биенээсээ суралцах, хамтран төлөвлөгөө боловсруулах боломжууд бидэнд байдаг.	
6.2 Хөдөлгөөний гишүүн болох олонд танигдсан байгууллага, эвсэл, сүлжээнээс бусад гишүүдтэй холбогдох, мэдээлэл өгөх ажлыг удирдаж, хөдөлгөөний үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаг.	
6.3 Хөдөлгөөний гишүүн болох олонд танигдсан байгууллага, эвсэл/ сүлжээний зүгээс хөдөлгөөнд нэгдсэн бусад байгууллагуудаа чадавхжуулахад шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлж байдаг.	
6.4 Манай хөдөлгөөн нь үр дүнтэй шийдвэр гаргах (хөдөлгөөний үйл ажиллагааны хүрээнд) тогтсон бүтэц, механизмтай.	
6.5 Манай хөдөлгөөнд, оролцогч тал, гишүүд өөрсдийн хөдөлгөөний амжилт ололт, саад бэрхшээлээ ил тод, үнэн шударгаар хэлэлцэж, ярилцах боломж бүрэн дүүрэн нээлттэй байдаг.	
7. Хүний эрхийн хамгаалагч хувь хүмүүс, байгууллагуудын аюулгүй байдал, хамгааллыг хамтаараа хангах чадавх сайн	
7.1 Манай хөдөлгөөн хүний эрхийн хамгаалагчдын эрх зөрчигдөх үед нэн даруй, зохих арга хэмжээг авах тодорхой механизмтай.	
7.2 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ нь, гишүүдийнхээ бие махбодийн аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй (олон нийтийн газар, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үеэр, ажлын байран дээр, гэртээ гэх мэт).	
7.3 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ дижитал (тоон системийн) аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй	
7.4 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй (өөрсдийгөө хэрхэн анхаарч, халамжилж буйг мөн хэмждэг)	

3-Р ХЭСЭГ: ХӨДӨЛГӨӨНИЙ НЭН ТЭРГҮҮНИЙ АСУУДЛУУД БОЛОН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЕ ШАТ

Хэмжигдэхүүн тус бүрийн дундаж үзүүлэлтэнд үндэслэн дараах асуултуудад хариулна уу.

1. Дараах хэмжигдэхүүнүүдийн аль нь танай хөдөлгөөний давуу тал болон бэрхшээл гэж та үзэж байна вэ?

Хэмжигдэхүүн	Давуу тал эсвэл бэрхшээл
1. Хүчтэй, тогтвортой, олон талын оролцогчидтой, олон нийтэд түшиглэсэн байдал [орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг]	o Давуу тал o Бэрхшээл
2. Олон талын төлөөллийг багтаасан манлайлагчид – дараагийн үеийн манлайлагчдын төлөөллийг мөн оролцуулна.	o Давуу тал o Бэрхшээл
3. Хөдөлгөөн дотроо гишүүд өөр хоорондоо болон бусад хамтрагч хөдөлгөөнүүдтэйгээ маш сайн хамтран ажилладаг.	o Давуу тал o Бэрхшээл
4. Нэгдмэл зорилготойгоор улс төр, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн (хөдөлгөөн нэгдмэл зорилготой эсэх)	o Давуу тал o Бэрхшээл
5. Бүгд нэгдсэн ойлголттойгоор хэрэгжүүлэх хэд хэдэн стратегийг ашигладаг.	o Давуу тал o Бэрхшээл
6. Манай хөдөлгөөн байгууллагын бүтэц, системийг сайн дэмждэг (нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн байгууллагууд, үр дүнтэй шийдвэр гаргах тогтолцоо, харилцаа холбооны систем гэх мэт)	o Давуу тал o Бэрхшээл

2. Дээр дурдсан үзүүлэлтүүдээс таны хөдөлгөөний сул тал, бэрхшээл гэж үзсэн хэмжигдэхүүнүүдийн алийг нь хөдөлгөөний хувьд одоогийн байдлаар хамгийн нэн тэргүүний чухал асуудал гэж бодож байна вэ (одоогийн байдлаар хамгийн чухал нь)? Таны нэн тэргүүнд авч үзсэн хоёр хэмжигдэхүүн буюу асуудлыг хэрхэн шийдвэрлэж, сайжруулах боломжтой гэж та үзэж байна вэ?

а. Хөдөлгөөний хувьд нэн тэргүүнд авч үзэж шаардлагатай чухал хэмжигдэхүүн буюу асуудал	б. Энэхүү хэмжигдэхүүн буюу асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөж байгаа вэ?
Нэн тэргүүний асуудал 1:	
Нэн тэргүүний асуудал 2:	

Дараах жагсаалт нь хөдөлгөөний үе шатууд болон эдгээрийн онцлог шинж чанарыг тайлбарласан¹. Доорх тайлбаруудыг уншсаны дараагаар өөрсдийн хөдөлгөөнийг хөгжлийн аль үе шатдаа явж байгааг тодорхойлоорой.

Үе шат	Онцлог/шинж чанар
Үүсэн бий болж байгаа хөдөлгөөн	<ul style="list-style-type: none"> • Нэгдэж эхлэх, ойлголт мэдлэг, адилтгал, өөрсдийн шинж чанараа таньж мэдэх; • Улс төрийн ухамсар бий болох, асуудлуудаа тодорхойлох; • Нэн тэргүүний, нэгдмэл зорилгоо тодорхойлох; • Өөрчлөлтийг бий болгохыг зорьж үйл ажиллагаа явуулж эхэлсэн; • Хөдөлгөөний манлайлагчаа сонгуулийн зарчмаар сонгодог; • Дэмжигч/санхүүжүүлэгч байгууллагаас ихээхэн хамааралтай байх
Бүрэлдэн тогтож байгаа хөдөлгөөн	<ul style="list-style-type: none"> • Тогтвортой, байнгын гишүүнчлэлтэй; • Улс төрийн өндөр ойлголт, ухамсартай болж, бүтцийн хувьд хувьсан, өөрчлөгдөж буй байдал; • Урт хугацааны улс төр, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилт, өөрчлөлтийн стратегитэй; • Дотоод манлайлал болон шийдвэр гаргах бүтэц тогтолцоотой; • Хамтран ажиллагч талуудын хамтын ажиллагааны цар хүрээ, хамтрагчдын тоо нэмэгдэх; • Дэмжлэг үзүүлэгч/санхүүжүүлэгч байгууллагуудаас илүү өөрсдөө бие даасан, хараат буй байдал нь давамгайлах; • Нийгэм, хууль эрх зүйн орчин, бодлогын түвшинд мэдэгдэхүйц өөрчлөлтийг авчирч, цаашид ч үр нөлөөлөл нь өсөх хандлагатай (тухайн асуудлын талаар хүмүүсийн хандлага, мэдрэмж илүү хүчтэй болох, хориг тавихад нөлөөлөх зэргийг мөн багтаана)

¹ Srilatha Batliwala-ийн боловсруулснаар (2003).

<p>Бүрэн төлөвшсөн хөдөлгөөн</p>	<ul style="list-style-type: none"> • Хөдөлгөөний нэгдмэл зорилгыг маш сайн ойлгосон, байнгын-тогтвортой гишүүнчлэлтэй; • Зохион байгуулалт, засаглалын бүтцийн хувьд бүрэн биеэ даасан; • Өргөн хүрээний, хүчтэй манлайлалтай; • Олон талаас нь тооцоолсон дүн шинжилгээ, стратеги, улс төрийн шийдвэр гаргалт, үйл ажиллагааг үнэн зөв, бодитоор үзэх үзэл хандлагатай; • Төрийн болон төрийн бус байгууллага, нийт олон нийт, нийгэмд, хэмжигдэхүйц томоохон өөрчлөлт, үр нөлөөг бий болгосон; • Стратегийн хамтран зүтгэгч болон өрсөлдөгч буюу сөрөг хүчинтэй болсон.
<p>Зогсонги байдалд орсон эсвэл уналтанд орсон хөдөлгөөн</p>	<ul style="list-style-type: none"> • Гишүүнчлэл нь зогсонги болсон эсвэл тасралтгүй буурч байгаа; • Хөдөлгөөний зорилго, чиглэлтэй холбоо хамааралгүй, асуудалтайгаа уялдаагүй улс төрийн хэвшмэл, тогтсон дүн шинжилгээ, арга барилтай болсон; • Үр нөлөөлөл нь маш хумигдмал эсвэл үр нөлөө нь буурч буй нэгэн хэвийн стратеги, үйл ажиллагаатай болсон • Нэгдсэн зорилго болсон асуудлаасаа хазайж гажсан, улс төр, эдийн засаг, нийгмийн орчин, шийдвэр гаргачид өөрчлөгдөх, хөдөлгөөнд түүхэн өөрчлөлт бий болох; • Манлайлал, зорилго/хөтөлбөр, гишүүнчлэл гэх мэт нь хуучрах, байхгүй болох, насжилт өндөр болох; • Бусад хөдөлгөөнүүд гарч ирэх/сэргэн мандах.

Дээр дурдсан тайлбарын хүрээнд танай хөдөлгөөн ерөнхийдөө аль үе шатанд явж байна гэж та бодож байна вэ?

- Үүсэн бий болж байгаа хөдөлгөөн
- Бүрэлдэн тогтож байгаа хөдөлгөөн
- Бүрэн төлөвшсөн хөдөлгөөн
- Зогсонги байдалд орсон эсвэл уналтанд орсон хөдөлгөөн

4-Р ХЭСЭГ: ОРОЛЦОГЧИД

Энэ хэсэгт бид, хөдөлгөөний чадавхийн үнэлгээнд хэн оролцож байгаа талаар болон хэний үзэл бодол үнэлгээний үр дүнд хэрхэн тусгагдаж буй талаар илүү ойлголт авах зорилгоор таны талаар болон танай байгууллагын талаар мэдээлэл авах хүсэлтэй байна. Таны өгсөн мэдээлэл нууцлагдах бөгөөд бүх цуглуулсан дата, мэдээллийн нэгтгэсэн үр дүнг танилцуулагдах болно.

1. Та энэхүү үнэлгээнд өөрийн харьяалагддаг/ажилладаг байгууллага эсвэл бүлгийг төлөөлөн оролцож байна уу?

- Тийм, би байгууллага/бүлгийг төлөөлөн оролцож байна.
- Үгүй, би активист/идэвхтэн хувь хүн эсвэл эксперт/мэргэжилтний хувиар оролцож байна.

Байгууллага эсвэл бүлгийн нэр:

Байгууллагын төрөл (нэгийг сонгоно уу):

<ul style="list-style-type: none">• Олон улсын сүлжээ, эвсэл (нэгээс олон тивийн нэгээс олон улсад үйл ажиллагаа явуулдаг)• Бүсийн хэмжээний сүлжээ, эвсэл (нэг тивд нэгээс олон улсад үйл ажиллагаа явуулдаг)• Үндэсний сүлжээ, эвсэл• Үндэсний хэмжээний бүсийн сүлжээ, эвсэл (хэд хэдэн аймгуудад үйл ажиллагаа явуулдаг)	<ul style="list-style-type: none">• Орон нутгийн сүлжээ, эвсэл (дүүрэг/аймаг/муж)• Олон улсын ашгийн бус байгууллага, судалгааны төв, хүрээлэн• Үндэсний хэмжээний ашгийн бус байгууллага, судалгааны төв, хүрээлэн• Иргэдтэй тулж ажилладаг байгууллага• Хувь хүн/активист• Төрийн байгууллага (төрийн захиргаа, удирдлага, сургууль цэцэрлэг, төрийн өмчит бүх хэлбэрийн байгууллага)• Санхүүжүүлэгчид (эмэгтэйчүүдийн сан, бусад сангуудыг мөн хандивлагчид авч үзнэ)
---	--

2. Танай байгууллага энэхүү хөдөлгөөнд ямар үндсэн үүрэгтэй вэ? Хэрэв та ямар нэгэн байгууллагыг төлөөлөөгүй, хувь хүний үүднээс үнэлгээнд оролцож байгаа бол та энэхүү хөдөлгөөнд ямар үүрэг, оролцоотой вэ? Дор дурдсан ангиллуудаас таны үүрэг, оролцоог хамгийн зөвөөр тодорхойлж буй 2 хүртэлх тайлбарыг сонгоно уу.

<ul style="list-style-type: none"> • Олон нийт эсвэл орон нутгийн иргэдийн мэдлэг ойлголт, ухамсрыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх • Гишүүд, дэмжигчдийг элсүүлэх, зохион байгуулалтанд оруулах • Манлайллыг бэхжүүлэх, хөгжүүлэх • Эвслийг үүсгэн бий болгох эсвэл бэхжүүлэх • Стратегийн дэмжлэг (судалгаа явуулах, дүн шинжилгээ хийх, баримт нотолгоо бүрдүүлэх, стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх зэргийг стратегийн дэмжлэг ангилалд авч үзнэ) 	<ul style="list-style-type: none"> • Үйлчилгээ хүргэх • Бодлогын нөлөөлөл • Бусад байгууллага эсвэл бүлгийн чадавхийг бэхжүүлэх • Хөрөнгө босгох болон нөөцийг удирдах, төлөвлөх • Байгууллага болон системийн суурь үндсэн бүтцийг дэмжих (ажиллах орон зайгаар хангах, захиргааны дэмжлэг үзүүлэх, Мэдээлэл, харилцааны технологийн системийн дэмжлэг үзүүлэх, хурал уулзалт зохион байгуулах байраар хангах гэх мэт)
---	--

3. Энэхүү үнэлгээнд хамрагдсан хүн тус бүрийн талаар дараах мэдээллийг бөглөнө үү. Шаардлагатай бол нэмэлт мөр ашиглана уу.

	Оролцогчийн нас	Оролцогч тус бүр нь энэхүү хөдөлгөөний үйл ажиллагаанд хэдэн жил оролцож байгаа байгаа вэ?	Оролцогч өөрийнхөө жендэрийг хэрхэн тодорхойлдог вэ?
Оролцогч 1	<ul style="list-style-type: none"> • 35 – аас доош • 35 – аас дээш 		
Оролцогч 2	<ul style="list-style-type: none"> • 35 – аас доош • 35 – аас дээш 		
Оролцогч 3	<ul style="list-style-type: none"> • 35 – аас доош • 35 – аас дээш 		

4. Бид аль болох олон талууд, оролцогчдын санал бодол, дуу хоолойг энэхүү үнэлгээндээ оруулахыг зорьж байгаа юм. Таны зүгээс, энэхүү үнэлгээнд орох боломжтой хамаарал бүхий эсвэл оруулах шаардлагатай гэж үзэж буй хувь хүн, байгууллагыг бидэнд санал болгоно уу.

Нэр	Байгууллага – харъяалал	Имэйл хаяг

5. САНАМЖ ЗӨВЛӨМЖ

Энэхүү аргачлалыг ашиглах явцад танд ямар хүндрэл бэрхшээл тулгарсан, таны сонгож авсан хөдөлгөөний чадавхийг үнэлэхэд энэ үнэлгээний арга зүй нь хэр тохиромжтой байсан, хэрэглэхэд хэр хялбар байсан талаар өөрийн саналыг Монголын эмэгтэйчүүдийн сангийн admin@mones.org.mn хаягаар ирүүлээрэй. Мөн цаашид юун дээр анхаарах, ямар асуулт, мэдээлэл зайлшгүй оруулах шаардлагатай, ойлгомжгүй зүйлс юу байсан талаар бидэнтэй хуваалцаарай.

Бид дуртайяа таны саналыг хүлээн авч, цаашид энэхүү аргачлалаа сайжруулахад анхаарч, таны санал, хүсэлтийг тусгах болно.

ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДАВХИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Хөдөлгөөний чадавхийн үнэлгээний аргачлал нь бүх оролцогч талуудын оролцоотойгоор нэг арга зүйгээр үнэлэх зорилготой юм.

Үнэлгээнд хамрагдаж буй хөдөлгөөний оролцогчид, хувь хүмүүсээс цахимаар судалгаа авах нь тохиромжгүй эсвэл боломжгүй тохиолдлууд нэлээд гардаг. Жишээ нь, аргачлал нь оролцогчийн мэдэхгүй хэл дээр, интернетийн хурд, чанар судалгааг бөглөхөд хангалтгүй, цахимаар судалгааг бөглөхөд цахим орчны аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй, хөдөлгөөний гишүүд, оролцогч талуудын хоорондын харилцаа гэх мэтийг дурдаж болно. Ийм учир зохион байгуулагчийн зүгээс аль болох олон оролцогчдын төлөөллийг оролцуулан, цахимаар болон биечлэн оролцох боломжийг бүрдүүлсэн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах нь үр дүнтэй юм.

Үнэлгээг зохион байгуулах алхмууд:

1. Энэхүү аргачлал нь танд зориулагдсан эсэхийг шалгаж, баталгаажуулна

Үнэлгээнд хамруулахаар сонгосон хөдөлгөөн нь дараах шалгуур үзүүлэлтэд нийцэж байвал энэхүү аргачлалыг ашиглана.

- Тухайн хөдөлгөөн нь нийтлэг-тулгамдсан асуудлуудаа хамтын, нэгдмэл үйл ажиллагаатайгаар шийдвэрлэх замаар одоогийн нөхцөл байдлыг өөрчлөх зорилготой нэгдэж, зохион байгуулалтад орсон хувь хүмүүс, байгууллагуудаас бүрдсэн байна.
- Эдгээр хувь хүмүүс, байгууллагууд нь тухайн хөдөлгөөнийг байдаг гэдгийг мөн үйл ажиллагааг нь мэддэг, мөн өөрсдийгөө хөдөлгөөний нэг хэсэг гэж үздэг.
- Эдгээр хувь хүмүүс, байгууллагууд энэхүү үнэлгээнд хамрагдсанаар бий болох ач холбогдол, үр ашиг нь учирч болох эрсдэлээс илүү байх.
- Зохион байгуулагч байгууллагын хувьд, та эсвэл танай байгууллага үнэлгээнд хамрагдах хөдөлгөөний оролцогч талуудтай холбоо харилцаа тогтоох боломжтой байх.

2. Үнэлгээнд хамруулах хөдөлгөөнөө тодорхойлно

Бүлгийн хэлэлцүүлэгт хамрагдах хүмүүс өөрсдийгөө хөдөлгөөний нэг хэсэг гэж ойлгодог байх нь маш чухал. Уулзалт зохион байгуулахын өмнө зохион байгуулагч байгууллага оролцогчдын төлөөлөлтэй уулзаж тухайн хөдөлгөөнийг оролцогчид хэрхэн тодорхойлж байгаа талаар ярилцах нь зүйтэй. Хөдөлгөөний гишүүн, оролцогч бүрийн тухайн хөдөлгөөний талаарх ойлголт, тодорхойлолт харилцан адилгүй байж болно. Тиймээс тухайн нэг сонгосон хөдөлгөөнийг үнэлэх гэж байгаа гэдгийг ойлгуулах нь чухал юм.

3. Хөдөлгөөний оролцогч талуудыг тодорхойлж, урьж оролцуулах

Ярилцлагыг үр дүнтэй явуулах зорилгоор бид дараах асуудлыг анхаарахыг та бүхэнд зөвлөж байна. Үүнд:

- Ярилцлага авах бүлэг нь цөөн хүнтэй байх (20 хүнээс хэтрэхгүй)
- Хөдөлгөөн дотроо өөр өөр үүрэг оролцоотой, ялгаатай санал бодолтой хувь хүн, байгууллагын төлөөллийг оролцуулах
- Бүлгийн ярилцлагын чиглүүлэгчээр тухайн хөдөлгөөний талаар сайн мэддэг, хөдөлгөөний оролцогч талууд, гишүүдийн дунд нэр хүндтэй, бие даасан, аль нэг талыг илт баримталдаггүй, төвийг сахисан хүнийг сонгох нь зүйтэй.

4. Бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулах, чиглүүлэх

Бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулах аргачлал, загвар нь тухайн хөдөлгөөний онцлог, орон нутгийн ялгаатай шинж байдал, агуулгаас шалтгаалах хэдий ч дор дурдсан жишээг ашиглах боломжтой.

Жишээ 1: Оролцогч хувь хүмүүс асуултуудад эхлээд нэг, нэгээрээ хариулж үзсэний дараагаар үр дүнгээ нэгтгэж хэлэлцэхдээ бүлэг болж дараах байдлаар ажиллана:

- а. Хавсралт А-ын дагуу асуултуудыг хөндлөнгийн оролцоогүйгээр оролцогч бүр нэг нэгээрээ бөглөнө.
- б. Судалгааны хариултуудыг бөглөсөн хуудсуудыг цуглуулж, хэлэлцүүлгийн завсарлагаанаар үр дүнг нэгтгэнэ (завсарлагааны үеэр үр дүнг нэгтгэх хангалттай цаг тавина).
- с. Оролцогчид завсарлагаанаас орж ирсний дараа, оролцогчдод нэгтгэсэн үр дүнг танилцуулна. Танилцуулгадаа оролцогчдын хариулсан хөдөлгөөний давуу тал, бэрхшээл, нэн тэргүүнд хэлэлцэх, шийдвэрлэх асуудлуудыг онцлон тусгана.
- д. Үр дүн болон цаашдын алхамуудаа хэлэлцэнэ.
 - Судалгааны үр дүнгээс юу нь таныг хамгийн их гайхшруулсан хариулт юу байсан вэ?
 - Ямар ямар хүчин зүйлс нь бидний харж буй чиг хандлага, асуудлуудыг тайлбарлаж болохоор байна вэ?
 - Танд ямар нэмэлт асуулт байна вэ?
 - Нэн тэргүүний тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, тэргүүнд тавьсан зорилтдоо хүрэхийн тулд бид хамтаараа юу хийж болох вэ?
 - Бидэнд өнөөгийн байдлаар ямар нөөц, боломж байгаа вэ?
 - Бидэнд цаашдаа ямар нөөц боломж хэрэгтэй болох вэ?
 - Бидний дараагийн алхмууд юу байх вэ?

Жишээ 2: Харилцан хамаарлын (Интерактив) зураглал

а. Энэхүү гарын авлагын Хавсралт В-ийн 1-р хэсэгт дүрсэлсэнтэй адил, нилээн том хүснэгт зураад 7 хэмжигдэхүүнийг өрөөний хананд наана. Хэмжигдэхүүн тус бүр “давуу тал”, “бэрхшээл”, “нэн тэргүүний асуудал” гэсэн баганатай байна. Мөн нийгмийн хөдөлгөөний 4 үе шатыг бичсэн тусдаа хуудас бэлтгэнэ.

б. Оролцогч бүрт 3 өнгийн дүрс эсвэл 3 өнгийн маркер өгнө. Нэг өнгө нь давуу тал, нэг өнгө нь бэрхшээл, нэг өнгө нь нэн тэргүүний асуудлыг илэрхийлнэ (F алхамыг харна уу)

с. Хавсралт В-ийн 2-р хэсгийг оролцогч тус бүрт хэвлэж өгнө.

д. Үүний дараагаар оролцогчдод, өрөөний хананд наасан хэмжигдэхүүн тус бүр нь тодорхойлолтын дагуу давуу тал уу эсвэл бэрхшээл үү гэдгийг тодорхойлж, тэмдэглэх даалгавар өгнө. Түүнчлэн оролцогчдоос тэдний хөдөлгөөн хөгжлийн аль үе шатандаа явж буй талаар санал хураалт авна.

е. Оролцогчид бүгд санал хураалтанд оролцсоны дараагаар оролцогчдыг цуглуулан гарсан үр дүнг дараах байдлаар хэлэлцэнэ:

- Аль нэг хэмжигдэхүүн нь маш тодорхой давуу тал эсвэл бэрхшээл болж байна уу?
- Аль үр дүн нь таныг хамгийн их гайхашруулсан бэ?
- Ямар ямар хүчин зүйлс нь бидний харж буй чиг хандлага, асуудлуудыг тайлбарлаж болохоор байна вэ?
- Танд ямар нэмэлт асуулт байна вэ?

ф. Оролцогчдоос үр дүнг харуулсан хэмжигдэхүүнүүдээс хөдөлгөөнийг чадавхжуулахад хамгийн чухал гэж үзсэн хоёр хэмжигдэхүүнийг дахин сонгох даалгавар өгнө.

г. Оролцогчдын санал хураалтыг нэгтгэн, хамгийн чухал гэж үзсэн хоёр хэмжигдэхүүнийг тодорхойлно. Оролцогчдыг цуглуулан дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хийнэ:

- Оролцогчдын сонгосон хамгийн чухал асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бид хамтаараа юу хийж болох вэ?
- Бидэнд одоогоор ямар нөөц байгаа вэ?
- Бидэнд цаашдаа ямар нөөц хэрэгтэй вэ?
- Бидний дараагийн алхам юу байх вэ?

ХАВСРАЛТ А: ХӨДӨЛГӨӨНИЙ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛЫН АЖЛЫН ХҮСНЭГТ

Танай хөдөлгөөний талаарх доорх мэдэгдлүүдтэй та хэр санал нийлж байна?
Асуулт/өгүүлбэр бүрт өөрийн хариултыг тохирох оноогоор үнэлнэ үү.

Танай хөдөлгөөний талаарх доорх мэдэгдлүүдтэй та хэр санал нийлж байна?	
1=огтхон ч үгүй; 2=бага зэрэг; 3=тодорхой хэмжээнд; 4=боломжийн хэмжээнд; 5=маш их; 0=мэдэхгүй;	
1. Хүчтэй, тогтвортой, олон талын оролцогчидтой, олон нийтэд түшиглэсэн байдал [орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг]	
1.1 Энэхүү хөдөлгөөний оролцогч талууд, гишүүд нь тухайн асуудалд хамгийн их өртсөн хүн ам – олон нийтийн төлөөлөл болж чаддаг.	
1.2 Энэхүү хөдөлгөөний оролцогчид нь олон талт, ялгаатай хүн ам бүлгийг төлөөлдөг.	
1.3 Энэхүү хөдөлгөөнийг дэмждэг, та бүхэнтэй нэгдэн, ямар нэгэн үйлдэл хийхэд бэлэн маш олон хүмүүс бий.	
1.4 Хүмүүс энэхүү хөдөлгөөнд нэгдэж орох олон боломжууд байдаг.	
1.5 Хөдөлгөөний шийдвэрлэхээр зорьсон, сонгож авсан асуудалд хамгийн их өртсөн хүмүүс өөрсдийнхөө төлөө дуу хоолойгоо нэгтгэн, орон нутагтаа бусдыгаа манлайлж, энэхүү өөрчлөлтийн үйл явцыг өөриймсгөөр авч үздэг.	
2. Олон талын төлөөллийг багтаасан манлайлагчид – дараагийн үеийн манлайлагчдын төлөөллийг мөн оролцуулна.	
2.1 Залуу манлайлагчдын хөдөлгөөнд оруулж буй хувь нэмрийг хөдөлгөөний бусад оролцогч талууд, гишүүд хүлээн зөвшөөрдөг.	
2.2 Үе, үеийн (generational) манлайлагчид өөр хоорондоо санал бодол, мэдлэг ур чадвараа хуваалцаж, хамтран ажилладаг.	
2.3 Тухайн асуудалд хамгийн их өртсөн орон нутгийн манлайлагчид болон шинэ үеийн манлайлагчид гэх мэт хөдөлгөөн дотроо шинэ манлайллыг бэлтгэх, хөгжүүлэх, дэмжих тодорхой механизм байдаг.	
2.4 Хөдөлгөөний манлайлагч (манлайлагчид) нь гишүүд, оролцогч талуудынхаа хэрэгцээ шаардлага, тэдний санал хүсэлтийг үргэлж нээлттэй хүлээн авч, хөдөлгөөний зорилго, хөтөлбөртөө хэрэгцээ шаардлага, эдгээр саналыг тусгаж, хэрэгжүүлж ажилладаг.	
3. Хөдөлгөөн дотроо гишүүд өөр хоорондоо болон бусад хамтрагч хөдөлгөөнүүдтэйгээ маш сайн хамтран ажилладаг.	
3.1 Энэ хөдөлгөөнд багтдаг бүлгүүд хоорондоо маш нягт хамтран ажилладаг.	
3.2 Энэ хөдөлгөөнд багтдаг бүлгүүд эмэгтэйчүүдийн, өөртөө туслах, оюутнуудын гэх мэт албан бус бүлгүүдтэй (эрх зүйн тодорхой статусгүй бүлэг хүмүүсийн төлөөлөл ЭСВЭЛ маш жижиг болон дотроо ямарваа нэгэн албан ёсны бүтэц байхгүй бүлгүүд) холбогдож, үйл ажиллагаандаа маш идэвхтэй хамруулдаг.	

3.3 Манай хөдөлгөөний үйл ажиллагаанд бусад хамтрагч хөдөлгөөнүүд идэвхтэй оролцож, дэмжлэг туслалцаа үзүүлж байдаг.	
3.4 Энэхүү хөдөлгөөнд багтдаг бүлгүүд манай хөдөлгөөний үйл ажиллагаанаас гадна, нийгмийн шударга ёс, хүний эрхийн бусад асуудлуудаар идэвхтэй ажилладаг.	
4. Нэгдмэл зорилготойгоор улс төр, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн (хөдөлгөөн нэгдмэл зорилготой эсэх)	
4.1 Манай хөдөлгөөн маш тодорхой, урт хугацааны зорилго, алсын хараатай.	
4.2 Манай хөдөлгөөн богино хугацааны зорилго, зорилт, шийдвэрлэх асуудлуудаа маш тодорхой гаргаж ирж, тодорхойлсон.	
4.3 Тулгамдаж буй асуудлынхаа талаар нэгдмэл ойлголттой.	
4.4 Тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх боломжит шийдлүүдийн талаар нэгдмэл ойлголттой.	
4.5 Манай хөдөлгөөний гишүүд богино хугацаанд, өндөр зохион байгуулалттайгаар боломжийг маш сайн ашиглаж, хариу үйлдэл үзүүлж чаддаг.	
4.6 Манай хөдөлгөөн, хөдөлгөөн доторх болон хөдөлгөөнөөс гадуурх асуудлуудыг оновчтой томъёолж, нэг нэгэндээ мэдээлж байдаг.	
5. Бүгд нэгдсэн ойлголттойгоор хэрэгжүүлэх хэд хэдэн стратегийг ашигладаг.	
5.1 Хөдөлгөөний нэгдмэл зорилгодоо хүрэхийн тулд гишүүд, дэмжигч болох хувь хүмүүс, бүлгүүдийн зүгээс олон төрлийн стратегийг ашигладаг. Жишээлбэл, олон нийтийг зохион байгуулалтанд оруулах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, бодлогын дүн шинжилгээ, нөлөөллийн ажил, лобби, шүүхэд зарга мэдүүлэх, судалгаа гэх мэт стратегиуд байж болно.	
5.2 Хөдөлгөөний оролцогч талууд болох хувь хүмүүс, бүлгүүд, хөдөлгөөний нэгдсэн зорилгодоо хүрэхийн тулд өндөр зохион байгуулалттайгаар олон ялгаатай стратегиудыг ашигладаг.	
5.3 Стратеги боловсруулахад шаардлагатай баримт нотолгоо бий болгох зорилгоор хөдөлгөөнд нэгдсэн хувь хүмүүс, бүлгүүд нэгдсэн зохион байгуулалтанд орж хүчин чармайлт гаргадаг.	
5.4 Хөдөлгөөн өөр өөр зорилтот бүлгийн төлөөлөлтэй холбогдох, харилцаа холбоо тогтоохдоо оновчтой технологи, мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй ашиглаж чаддаг.	

6. Манай хөдөлгөөн байгууллагын бүтэц, системийг сайн дэмждэг (нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн байгууллагууд, үр дүнтэй шийдвэр гаргах тогтолцоо, харилцаа холбооны систем гэх мэт)	
6.1 Хөдөлгөөний гишүүн бүлгүүд хамтдаа цугларан, бие биенээсээ суралцах, хамтран төлөвлөгөө боловсруулах боломжууд бидэнд байдаг.	
6.2 Хөдөлгөөний гишүүн болох олонд танигдсан байгууллага, эвсэл, сүлжээнээс бусад гишүүдтэй холбогдох, мэдээлэл өгөх ажлыг удирдаж, хөдөлгөөний үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаг.	
6.3 Хөдөлгөөний гишүүн болох олонд танигдсан байгууллага, эвсэл/ сүлжээний зүгээс хөдөлгөөнд нэгдсэн бусад байгууллагуудаа чадавхжуулахад шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлж байдаг.	
6.4 Манай хөдөлгөөн нь үр дүнтэй шийдвэр гаргах (хөдөлгөөний үйл ажиллагааны хүрээнд) тогтсон бүтэц, механизмтай.	
6.5 Манай хөдөлгөөнд, оролцогч тал, гишүүд өөрсдийн хөдөлгөөний амжилт ололт, саад бэрхшээлээ ил тод, үнэн шударгаар хэлэлцэж, ярилцах боломж бүрэн дүүрэн нээлттэй байдаг.	
7. Хүний эрхийн хамгаалагч хувь хүмүүс, байгууллагуудын аюулгүй байдал, хамгааллыг хамтаараа хангах чадавх сайн	
7.1 Манай хөдөлгөөн хүний эрхийн хамгаалагчдын эрх зөрчигдөх үед нэн даруй, зохих арга хэмжээг авах тодорхой механизмтай.	
7.2 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ нь, гишүүдийнхээ бие махбодийн аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй (олон нийтийн газар, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үеэр, ажлын байран дээр, гэртээ гэх мэт).	
7.3 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ дижитал (тоон системийн) аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй.	
7.4 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй (өөрсдийгөө хэрхэн анхаарч, халамжилж буйг мөн хэмждэг)	

Хөдөлгөөний үе шатууд болон эдгээрийн онцлог шинж чанар (Srilatha Batiwala-ийн 2003 онд боловсруулснаар).

Дор дурдсан тайлбарыг уншиж, танилцан, танай хөдөлгөөн эдгээр тодорхойлолтын хүрээнд аль үе шатандаа явж байна гэдгээ тодорхойлоорой.

Үе шат	Онцлог/шинж чанар
Үүсэн бий болж байгаа хөдөлгөөн	<ul style="list-style-type: none"> • Нэгдэж эхлэх, ойлголт мэдлэг, адилтгал, өөрсдийн шинж чанараа таньж мэдэх; • Улс төрийн ухамсар бий болох, асуудлуудаа тодорхойлох; • Нэн тэргүүний, нэгдмэл зорилгоо тодорхойлох; • Өөрчлөлтийг бий болгохыг зорьж үйл ажиллагаа явуулж эхэлсэн; • Сонгуульт манлайллын зарчмыг бий болж буй; • Дэмжигч/санхүүжүүлэгч байгууллагаас ихээхэн хамааралтай байх
Бүрэлдэн тогтож байгаа хөдөлгөөн	<ul style="list-style-type: none"> • Тогтвортой, байнгын гишүүнчлэлд суурилсан; • Улс төрийн ухамсрын талаар өндөр ойлголттой болж, бүтцийн хувьд хувьсан, өөрчлөгдөж буй; • Урт хугацааны улс төр, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилт, өөрчлөлтийн стратегитэй; • Дотоод манлайлал болон шийдвэр гаргах бүтэц тогтолцоотой; • Хамтран ажиллагч талуудын хамтын ажиллагааны цар хүрээ, хамтрагчдын тоо нэмэгдэх; • Дэмжлэг үзүүлэгч/санхүүжүүлэгч байгууллагуудаас илүү өөрсдөө бие даасан, хараат буй байдал нь давамгайлах; • Нийгэм, хууль эрх зүйн орчин, бодлогын түвшинд мэдэгдэхүйц өөрчлөлтийг авчирч, цаашид ч үр нөлөөлөл нь өсөх хандлагатай (тухайн асуудлын талаар хүмүүсийн хандлага, мэдрэмж илүү хүчтэй болох, хориг тавихад нөлөөлөх зэргийг мөн багтаана)

<p>Бүрэн төлөвшсөн хөдөлгөөн</p>	<ul style="list-style-type: none"> • Хөдөлгөөний нэгдмэл зорилгыг маш сайн ойлгосон, байнгын-тогтвортой гишүүнчлэлтэй; • Зохион байгуулалт, засаглалын бүтцийн хувьд бүрэн биеэ даасан; • Өргөн хүрээний, хүчтэй манлайлалтай; • Олон талаас нь тооцоолсон дүн шинжилгээ, стратеги, улс төрийн шийдвэр гаргалт, үйл ажиллагааг үнэн зөв, бодитоор үзэх үзэл хандлагатай; • Төрийн болон төрийн бус байгууллага, нийт олон нийт, нийгэмд, хэмжигдэхүйц томоохон өөрчлөлт, үр нөлөөг бий болгосон; • Стратегийн хамтран зүтгэгч болон өрсөлдөгч буюу сөрөг хүчинтэй болсон.
<p>Зогсонги байдалд орсон эсвэл уналтанд орсон хөдөлгөөн</p>	<ul style="list-style-type: none"> • Гишүүнчлэл нь зогсонги болсон эсвэл тасралтгүй буурч байгаа; • Хөдөлгөөний зорилго, чиглэлтэй холбоо хамааралгүй, асуудалтайгаа уялдаагүй улс төрийн хэвшмэл, тогтсон дүн шинжилгээ, арга барилтай болсон; • Үр нөлөөлөл нь маш хумигдмал эсвэл үр нөлөө нь буурч буй нэгэн хэвийн стратеги, үйл ажиллагаатай болсон • Нэгдсэн зорилго болсон асуудлаасаа хазайж гажсан, улс төр, эдийн засаг, нийгмийн орчин, шийдвэр гаргачид өөрчлөгдөх, хөдөлгөөнд түүхэн өөрчлөлт бий болох; • Манлайлал, зорилго/хөтөлбөр, гишүүнчлэл гэх мэт нь хуучрах, байхгүй болох, насжилт өндөр болох; • Бусад хөдөлгөөнүүд гарч ирэх/сэргэн мандах.

- Үүсэн бий болж байгаа хөдөлгөөн
- Бүрэлдэн тогтож байгаа хөдөлгөөн
- Бүрэн төлөвшсөн хөдөлгөөн
- Зогсонги байдалд орсон эсвэл уналтанд орсон хөдөлгөөн

ХАВСРАЛТ В: ХАРИЛЦАН ХАМААРЛЫН (ИНТЕРАКТИВ) ЗУРАГЛАЛ БОЛОН ТАРААХ МАТЕРИАЛ

В.1 Бүлгийн үйл ажиллагаанд зориулсан тараах материал

Хүчтэй хөдөлгөөний 7 хэмжигдэхүүн:

1. Хүчтэй, тогтвортой, олон талын оролцогчидтой, олон нийтэд түшиглэсэн байдал [орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг]		
Давуу тал	Бэрхшээл	Нэн тэргүүнд анхаарах асуудал

2. Олон талын төлөөллийг багтаасан манлайлагчид – дараагийн үеийн манлайлагчдын төлөөллийг мөн оролцуулна.		
Давуу тал	Бэрхшээл	Нэн тэргүүнд анхаарах асуудал

3. Хөдөлгөөн дотроо гишүүд өөр хоорондоо болон бусад хамтрагч хөдөлгөөнүүдтэйгээ маш сайн хамтран ажилладаг.		
Давуу тал	Бэрхшээл	Нэн тэргүүнд анхаарах асуудал

4. Нэгдмэл зорилготойгоор улс төр, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн (хөдөлгөөн нэгдмэл зорилготой эсэх)		
Давуу тал	Бэрхшээл	Нэн тэргүүнд анхаарах асуудал

5. Бүгд нэгдсэн ойлголттойгоор хэрэгжүүлэх хэд хэдэн стратегийг ашигладаг.		
Давуу тал	Бэрхшээл	Нэн тэргүүнд анхаарах асуудал

6. Манай хөдөлгөөн байгууллагын бүтэц, системийг сайн дэмждэг (нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн байгууллагууд, үр дүнтэй шийдвэр гаргах тогтолцоо, харилцаа холбооны систем гэх мэт)

Давуу тал	Бэрхшээл	Нэн тэргүүнд анхаарах асуудал

7. Хүний эрхийн хамгаалагч хувь хүмүүс, байгууллагуудын аюулгүй байдал, хамгааллыг хамтаараа хангах чадавх сайн

Давуу тал	Бэрхшээл	Нэн тэргүүнд анхаарах асуудал

Нийгмийн хөдөлгөөний үе шатууд:

Үүсэн бий болж байгаа хөдөлгөөн	Бүрэлдэн тогтож байгаа хөдөлгөөн	Бүрэн төлөвшсөн хөдөлгөөн	Зогсонги байдалд орсон эсвэл уналтанд орсон хөдөлгөөн

B2. Хөдөлгөөний чадавхийн үнэлгээний аргачлалын тараах материал

Хэмжигдэхүүн	Тайлбар
<p>1. Хүчтэй, тогтвортой, олон талын оролцогчидтой, олон нийтэд түшиглэсэн байдал [орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг]</p> <p>2. Олон талын төлөөллийг багтаасан манлайлагчид – дараагийн үеийн манлайлагчдын төлөөллийг мөн оролцуулна.</p>	<p>1.1 Энэхүү хөдөлгөөний оролцогч талууд, гишүүд нь тухайн асуудалд хамгийн их өртсөн хүн ам – олон нийтийн төлөөлөл болж чаддаг.</p> <p>1.2 Энэхүү хөдөлгөөний оролцогчид нь олон талт, ялгаатай хүн ам бүлгийг төлөөлдөг.</p> <p>1.3 Энэхүү хөдөлгөөнийг дэмждэг, та бүхэнтэй нэгдэн, ямар нэгэн үйлдэл хийхэд бэлэн маш олон хүмүүс бий.</p> <p>1.4 Хүмүүс энэхүү хөдөлгөөнд нэгдэж орох олон боломжууд байдаг.</p> <p>1.5 Хөдөлгөөний шийдвэрлэхээр зорьсон, сонгож авсан асуудалд хамгийн их өртсөн хүмүүс өөрсдийнхөө төлөө дуу хоолойгоо нэгтгэн, орон нутагтаа бусдыгаа манлайлж, энэхүү өөрчлөлтийн үйл явцыг өөриймсгөөр авч үздэг.</p> <p>2.1 Залуу манлайлагчдын хөдөлгөөнд оруулж буй хувь нэмрийг хөдөлгөөний бусад оролцогч талууд, гишүүд хүлээн зөвшөөрдөг.</p> <p>2.2 Үе, үеийн (generational) манлайлагчид өөр хоорондоо санал бодол, мэдлэг ур чадвараа хуваалцаж, хамтран ажилладаг.</p> <p>2.3 Тухайн асуудалд хамгийн их өртсөн орон нутгийн манлайлагчид болон шинэ үеийн манлайлагчид гэх мэт хөдөлгөөн дотроо шинэ манлайллыг бэлтгэх, хөгжүүлэх, дэмжих тодорхой механизм байдаг.</p> <p>2.4 Хөдөлгөөний манлайлагч (манлайлагчид) нь гишүүд, оролцогч талуудынхаа хэрэгцээ шаардлага, тэдний санал хүсэлтийг үргэлж нээлттэй хүлээн авч, хөдөлгөөний зорилго, хөтөлбөртөө хэрэгцээ шаардлага, эдгээр саналыг тусгаж, хэрэгжүүлж ажилладаг.</p>

<p>3. Хөдөлгөөн дотроо гишүүд өөр хоорондоо болон бусад хамтрагч хөдөлгөөнүүдтэйгээ маш сайн хамтран ажилладаг.</p>	<p>3.1 Энэ хөдөлгөөнд багтдаг бүлгүүд хоорондоо маш нягт хамтран ажилладаг.</p> <p>3.2 Энэ хөдөлгөөнд багтдаг бүлгүүд эмэгтэйчүүдийн, өөртөө туслах, оюутнуудын гэх мэт албан бус бүлгүүдтэй (эрх зүйн тодорхой статусгүй бүлэг хүмүүсийн төлөөлөл ЭСВЭЛ маш жижиг болон дотроо ямарваа нэгэн албан ёсны бүтэц байхгүй бүлгүүд) холбогдож, үйл ажиллагаандаа маш идэвхтэй хамруулдаг.</p> <p>3.3 Манай хөдөлгөөний үйл ажиллагаанд бусад хамтрагч хөдөлгөөнүүд идэвхтэй оролцож, дэмжлэг туслалцаа үзүүлж байдаг.</p> <p>3.4 Энэхүү хөдөлгөөнд багтдаг бүлгүүд манай хөдөлгөөний үйл ажиллагаанаас гадна, нийгмийн шударга ёс, хүний эрхийн бусад асуудлуудаар идэвхтэй ажилладаг.</p>
<p>Нэгдмэл зорилготойгоор улс төр, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн (хөдөлгөөн нэгдмэл зорилготой эсэх)</p>	<p>4.1 Манай хөдөлгөөн маш тодорхой, урт хугацааны зорилго, алсын хараатай.</p> <p>4.2 Манай хөдөлгөөн богино хугацааны зорилго, зорилт, шийдвэрлэх асуудлуудаа маш тодорхой гаргаж ирж, тодорхойлсон.</p> <p>4.3 Тулгамдаж буй асуудлынхаа талаар нэгдмэл ойлголттой.</p> <p>4.4 Тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх боломжит шийдлүүдийн талаар нэгдмэл ойлголттой.</p> <p>4.5 Манай хөдөлгөөний гишүүд богино хугацаанд, өндөр зохион байгуулалттайгаар боломжийг маш сайн ашиглаж, хариу үйлдэл үзүүлж чаддаг.</p> <p>4.6 Манай хөдөлгөөн, хөдөлгөөн доторх болон хөдөлгөөнөөс гадуурх асуудлуудыг оновчтой томъёолж, нэг нэгэндээ мэдээлж байдаг.</p>

<p>5. Бүгд нэгдсэн ойлголтойгоор хэрэгжүүлэх хэд хэдэн стратегийг ашигладаг.</p>	<p>5.1 Хөдөлгөөний нэгдмэл зорилгодоо хүрэхийн тулд гишүүд, дэмжигч болох хувь хүмүүс, бүлгүүдийн зүгээс олон төрлийн стратегийг ашигладаг. Жишээлбэл, олон нийтийг зохион байгуулалтанд оруулах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, бодлогын дүн шинжилгээ, нөлөөллийн ажил, лобби, шүүхэд зарга мэдүүлэх, судалгаа гэх мэт стратегиуд байж болно.</p> <p>5.2 Хөдөлгөөний оролцогч талууд болох хувь хүмүүс, бүлгүүд, хөдөлгөөний нэгдсэн зорилгодоо хүрэхийн тулд өндөр зохион байгуулалттайгаар олон ялгаатай стратегиудыг ашигладаг.</p> <p>5.3 Стратеги боловсруулахад шаардлагатай баримт нотолгоо бий болгох зорилгоор хөдөлгөөнд нэгдсэн хувь хүмүүс, бүлгүүд нэгдсэн зохион байгуулалтанд орж хүчин чармайлт гаргадаг.</p> <p>5.4 Хөдөлгөөн өөр өөр зорилтот бүлгийн төлөөлөлтэй холбогдох, харилцаа холбоо тогтоохдоо оновчтой технологи, мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй ашиглаж чаддаг.</p>
<p>6. Манай хөдөлгөөн байгууллагын бүтэц, системийг сайн дэмждэг (нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн байгууллагууд, үр дүнтэй шийдвэр гаргах тогтолцоо, харилцаа холбооны систем гэх мэт)</p>	<p>6.1 Хөдөлгөөний гишүүн бүлгүүд хамтдаа цугларан, бие биенээсээ суралцах, хамтран төлөвлөгөө боловсруулах боломжууд бидэнд байдаг.</p> <p>6.2 Хөдөлгөөний гишүүн болох олонд танигдсан байгууллага, эвсэл, сүлжээнээс бусад гишүүдтэй холбогдох, мэдээлэл өгөх ажлыг удирдаж, хөдөлгөөний үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулдаг.</p> <p>6.3 Хөдөлгөөний гишүүн болох олонд танигдсан байгууллага, эвсэл/сүлжээний зүгээс хөдөлгөөнд нэгдсэн бусад байгууллагуудаа чадавхжуулахад шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлж байдаг.</p> <p>6.4 Манай хөдөлгөөн нь үр дүнтэй шийдвэр гаргах (хөдөлгөөний үйл ажиллагааны хүрээнд) тогтсон бүтэц, механизмтай.</p> <p>6.5 Манай хөдөлгөөнд, оролцогч тал, гишүүд өөрсдийн хөдөлгөөний амжилт ололт, саад бэрхшээлээ ил тод, үнэн шударгаар хэлэлцэж, ярилцах боломж бүрэн дүүрэн нээлттэй байдаг.</p>

<p>7. Хүний эрхийн хамгаалагч хувь хүмүүс, байгууллагуудын аюулгүй байдал, хамгааллыг хамтаараа хангах чадавх сайн</p>	<p>7.1 Манай хөдөлгөөн хүний эрхийн хамгаалагчдын эрх зөрчигдөх үед нэн даруй, зохих арга хэмжээг авах тодорхой механизмтай.</p> <p>7.2 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ нь, гишүүдийнхээ бие махбодийн аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй (олон нийтийн газар, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үеэр, ажлын байран дээр, гэртээ гэх мэт).</p> <p>7.3 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ дижитал (тоон системийн) аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй.</p> <p>7.4 Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй (өөрсдийгөө хэрхэн анхаарч, халамжилж буйг мөн хэмждэг)</p>
--	--

Нийгмийн хөдөлгөөний үе шатууд болон тэдгээрийн онцлог шинж чанар

Хэмжигдэхүүн	Тайлбар
<p>Үүсэн бий болж байгаа хөдөлгөөн</p>	<ul style="list-style-type: none"> • Нэгдэж эхлэх, ойлголт мэдлэг, адилтгал, өөрсдийн шинж чанараа таньж мэдэх; • Улс төрийн ухамсар бий болох, асуудлуудаа тодорхойлох; • Нэн тэргүүний, нэгдмэл зорилгоо тодорхойлох; • Өөрчлөлтийг бий болгохыг зорьж үйл ажиллагаа явуулж эхэлсэн; • Сонгуульт манлайллын зарчмыг бий болж буй; • Дэмжигч/санхүүжүүлэгч байгууллагаас ихээхэн хамааралтай байх

<p>Бүрэлдэн тогтож байгаа хөдөлгөөн</p>	<ul style="list-style-type: none"> • Тогтвортой, байнгын гишүүнчлэлд суурилсан; • Улс төрийн ухамсрын талаар өндөр ойлголттой болж, бүтцийн хувьд хувьсан, өөрчлөгдөж буй; • Урт хугацааны улс төр, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилт, өөрчлөлтийн стратегитэй; • Дотоод манлайлал болон шийдвэр гаргах бүтэц тогтолцоотой; • Хамтран ажиллагч талуудын хамтын ажиллагааны цар хүрээ, хамтрагчдын тоо нэмэгдэх; • Дэмжлэг үзүүлэгч/санхүүжүүлэгч байгууллагуудаас илүү өөрсдөө бие даасан, хараат буй байдал нь давамгайлах; • Нийгэм, хууль эрх зүйн орчин, бодлогын түвшинд мэдэгдэхүйц өөрчлөлтийг авчирч, цаашид ч үр нөлөөлөл нь өсөх хандлагатай (тухайн асуудлын талаар хүмүүсийн хандлага, мэдрэмж илүү хүчтэй болох, хориг тавихад нөлөөлөх зэргийг мөн багтаана)
<p>Бүрэн төлөвшсөн хөдөлгөөн</p>	<ul style="list-style-type: none"> • Хөдөлгөөний нэгдмэл зорилгыг маш сайн ойлгосон, байнгын-тогтвортой гишүүнчлэлтэй; • Зохион байгуулалт, засаглалын бүтцийн хувьд бүрэн биеэ даасан; • Өргөн хүрээний, хүчтэй манлайлалтай; • Олон талаас нь тооцоолсон дүн шинжилгээ, стратеги, улс төрийн шийдвэр гаргалт, үйл ажиллагааг үнэн зөв, бодитоор үзэх үзэл хандлагатай; • Төрийн болон төрийн бус байгууллага, нийт олон нийт, нийгэмд, хэмжигдэхүйц томоохон өөрчлөлт, үр нөлөөг бий болгосон; • Стратегийн хамтран зүтгэгч болон өрсөлдөгч буюу сөрөг хүчинтэй болсон.

<p>Зогсонги байдалд орсон эсвэл уналтанд орсон хөдөлгөөн</p>	<ul style="list-style-type: none"> • Гишүүнчлэл нь зогсонги болсон эсвэл тасралтгүй буурч байгаа; • Хөдөлгөөний зорилго, чиглэлтэй холбоо хамааралгүй, асуудалтайгаа уялдаагүй улс төрийн хэвшмэл, тогтсон дүн шинжилгээ, арга барилтай болсон; • Үр нөлөөлөл нь маш хумигдмал эсвэл үр нөлөө нь буурч буй нэгэн хэвийн стратеги, үйл ажиллагаатай болсон • Нэгдсэн зорилго болсон асуудлаасаа хазайж гажсан, улс төр, эдийн засаг, нийгмийн орчин, шийдвэр гаргачид өөрчлөгдөх, хөдөлгөөнд түүхэн өөрчлөлт бий болох; • Манлайлал, зорилго/хөтөлбөр, гишүүнчлэл гэх мэт нь хуучрах, байхгүй болох, насжилт өндөр болох; • Бусад хөдөлгөөнүүд гарч ирэх/сэргэн мандах.
--	--

Хөдөлгөөний чадавхийн үнэлгээний аргачлал болон аргачлалтай холбоотой бусад баримт бичгүүд нь Creative Commons Attribution-NonCommercial ShareAlike 4.0-д олон улсын зөвшөөрөл авсан. Зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг дараах хуудаснаас харах боломжтой:

<http://creativecommons.org/licenses/by-nc-sa/4.0/>

ДОРНОД АЙМГИЙН "ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨХ НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА" ХӨДӨЛГӨӨНИЙ ЖИШЭЭ, ҮР ДҮН

Дэлхийн эмэгтэйчүүдийн сангаас (Global Fund for Women) хөдөлгөөний чадавхийг үнэлэх аргачлалыг боловсруулж, бусад орнуудын эмэгтэйчүүдийн сангуудтай хамтран туршилтын журмаар эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хамгаалах нийгмийн хөдөлгөөнүүдэд үнэлгээ хийсэн. Энэхүү туршилтын үнэлгээнд МОНЭС бусад 5 орны эмэгтэйчүүдийн сангуудтай хамтран оролцсон.

Үнэлгээнд хамрагдсан хөдөлгөөнийг хэрхэн сонгосон бэ?

МОНЭС-гаас Улаанбаатар хотын агаарын бохирдол, утааг багасгах зорилготой нийгмийн хөдөлгөөн, Завхан аймагт шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах хөдөлгөөн, Дорнод аймагт Жендэрийн эрх тэгш байдлын төлөөх нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх хөдөлгөөн гэсэн 3 хөдөлгөөнийг нийгмийн хөдөлгөөний чадавхийг үнэлгээнд хамруулахаар урьдчилан сонгож авсан. Цаг хугацааны хязгаарлалт, төсвийн нөөц боломж, ажиллах хүмүүс, судалгааны мэдээлэл дүн шинжилгээ хийх боломж, мөн дээр дурдсан тодорхой асуудлуудыг гаргаж ирэхэд, оролцогч талуудын олон талт ялгаатай төлөөлөл, стратегийн цар хүрээ, цаг хугацааны хувьд тохиромжтой, газар зүйн байршил, эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хангахад илүү чиглэсэн байдлыг харгалзаж үзээд Дорнод аймаг дахь хөдөлгөөнийг сонгож, үнэлгээнд хамруулсан.

Үнэлгээнд хамрагдсан хөдөлгөөний оролцогч талууд, гишүүд:

Үнэлгээнд хамрагдах хөдөлгөөний оролцогч талуудыг хөдөлгөөний манлайлагч гишүүд төлөөллийн оролцоотойгоор хөдөлгөөний нэгдсэн зорилгод хүрэхээр зохион байгуулсан үйл ажиллагаа, стратегиудыг хэрэгжүүлсэн, удирдан зохион байгуулсан, оролцсон, дэмжсэн байгууллага, хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргаж, тэдэнд энэхүү аргачлалын талаар мэдээлэл өгч, үнэлгээнд оролцох хүсэлт илгээсэн. Мөн үнэлгээний асуултын дагуу, энэхүү үнэлгээнд хамрагдвал зохих, бусад оролцогч талын нэрсийг санал болгохыг хүсэж, оролцогчдын санал болгосон хүмүүсийг мөн урьж оролцуулсан.

Бэлтгэл ажил, үнэлгээг зохион байгуулсан үйл явц:

- Үнэлгээний мэдээллийг цуглуулахаас өмнө, хөдөлгөөний гишүүдтэй 4-5 удаагийн бүлгийн болон ганцаарчилсан уулзалт хийж, хөдөлгөөний үйл ажиллагаа болон үнэлгээний аргачлал, төлөвлөгөөний талаар мэдээлэл өгч, танилцуулж, нэг удаагийн бүх гишүүдийг хамруулсан нэгдсэн уулзалт зохион байгуулсан. Энэхүү уулзалтуудаар оролцогчдод үнэлгээний аргачлал, зорилгыг

танилцуулж, хэрхэн оролцох, яагаад та оролцож байгаа талаар мэдээлэл өгч, шалгуур үзүүлэлт буюу өөрийгөө үнэлэх checklist-ийн дагуу хөдөлгөөний гишүүн мөн эсэхийг нь оролцогчдоор өөрсдөөр нь тодорхойлуулсан. Энэ нь чадавхийн үнэлгээний аргачлалыг амжилттай ашиглах хүчин зүйлсийн нэг болсон.

- Хөдөлгөөний оролцогч талууд, гишүүд нь нийгмийн маш олон бүлгийг (сум багийн иргэд, өндөр настан, бичиг үсгийн боловсролын түвшин бага иргэд гэх мэт) төлөөлж байсан тул арга зүйн талаар мэдээлэл өгөхөөс гадна үнэлгээний асуултуудыг хэрхэн бөглөх, цахимаар хэрхэн нэвтэрч, мэдээллээ яаж оруулах гэх мэт техникийн тусламж үзүүлэх, үнэлгээний асуулт тус бүрийн цаана ямар мэдээлэл авахаар зорьж байгаа, энэ мэдээлэл нь ямар ач холбогдолтой, судалгаанд гишүүд оролцох нь ямар чухал болохыг тайлбарласан нь хүмүүсийн идэвхтэй оролцоо, бүрэн гүйцэд хариулт өгөхөд нөлөөлсөн.
- 2019 оны 4, 5 сард судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулж, 5, 6 сард мэдээллийг боловсруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг МОНЭС-ийн ажилтан, Дорнод аймгийн 2 ТББ байгууллага буюу орон нутгийн төлөөлөгчид зохион байгуулж, оролцогчдыг мэдээллээр хангах, шаардлагатай арга зүйн болон техникийн тусламж үзүүлж ажилласан. Үнэлгээний аргачлалын талаар мэдээлэл өгсний дараагаар нийт 3 долоо хоногт цахимаар мэдээлэл цуглуулсан.
- Дэлхий эмэгтэйчүүдийн сан үнэлгээний цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Зохион байгуулагч буюу бидний зүгээс судалгаанд оролцогчдын оролцоо, мэдээллийг бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь оруулахад хяналт тавьж ажилласан. Цаашид энэхүү аргачлалыг ашиглан өөр бусад эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг үнэлэх тохиолдолд цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, анализ хийх мэргэжилтэн зайлшгүй шаардлагатай бөгөөд энэхүү гарын авлагад хэрхэн дүн шинжилгээ хийх талаар мэдээлэл байхгүйг анхаарна уу.

Үнэлгээний үр дүн:

Үнэлгээнд 54 байгууллагын 55 төлөөлөл, 23 хүний эрхийн активист, мэргэжилтэн, судлаач, нийт 78 хүн, хөдөлгөөний оролцогч талуудыг төлөөлөн оролцсон.

Оролцогчдын хүн ам зүйн ерөнхий мэдээлэл:

- Төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний байгууллага – 23;
- Иргэний нийгмийн эвсэл, сүлжээний – 13;
- Орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа явуулдаг


- байгууллагууд – 9;
- Үндэсний эвсэл, сүлжээ – 7;
- Бусад байгууллага, агентлаг, төв – 3 төлөөлөл оролцсон.

Нийт оролцогчдын талаас дээш хувь нь буюу 60% нь хөдөлгөөн дотроо олон нийт, орон нутгийн иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцдог, энэ чиглэлээр түлхүү үүрэг хүлээж оролцдог гэж хариулсан байна. Мөн бодлогын нөлөөлөл (31%), үйлчилгээ хүргэх (18%), манлайллыг бэхжүүлэх, хөгжүүлэх (18%), стратегийн шинж чанартай дэмжлэг үзүүлэх (12%), хөдөлгөөн доторх болон хөдөлгөөний гаднах байгууллага, бүлгүүдийн чадавхийг бэхжүүлэх (10%), шинэ гишүүд, дэмжигчдийг элсүүлэх, нэгдсэн зохион байгуулалтанд оруулах (9%), байгууллага болон системийн суурь үндсэн бүтцийг дэмжих (8%), эвсэл, сүлжээ бий болгох, бэхжүүлэх (3%), хөрөнгө босгох болон нөөцийг удирдан төлөвлөх (1%) гэсэн үүрэг, оролцоотойгоор хөдөлгөөнд хувь нэмрээ оруулдаг байна. Судалгаанд оролцогчдын 86% хувь нь 35-аас дээш, үлдсэн 14 хувь нь 35-аас доош насны хүмүүс байсан байна. Мөн нийт 78 оролцогчийн 40 нь хөдөлгөөний үйл ажиллагаанд 4 болон түүнээс бага жил, 18 оролцогч 5-9 жил, 20 оролцогч 10 болон түүнээс дээш жил оролцож байна гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогчдын онцлог шинж чанар: 78 Оролцогч

Байгууллагын төрөл	#
Төрийн байгууллага	23
Орон нутгийн сүлжээ эсвэл эвсэл (дүүргийн/аймгийн/хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг)	13
Орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн эсвэл иргэдтэй тулж ажилладаг байгууллага (Grassroot байгууллага)	9
Үндэсний хэмжээний сүлжээ эсвэл эвсэл	7
Бүсийн хэмжээний сүлжээ эсвэл эвсэл (өөрийн тивдээ нэгээс олон улсад үйл ажиллагаа явуулдаг)	2
Үндэсний хэмжээний, ашгийн бус байгууллага, судалгааны төв эсвэл агенлаг	1

(ямар нэгэн байгууллага, бүлэгт харьяалагддаггүй) би бие даасан идэвхтэн, активист эсвэл мэргэжилтний хувиар оролцож байна = 23




Responses, би өөрийн (харьяалагддаг) байгууллага эсвэл бүлгийг төлөөлөн оролцож байна = 55, 71%

Судалгаанд оролцогчдын онцлог шинж чанар:
Хөдөлгөөнд гүйцэтгэх үүрэг, оролцоо



Судалгаанд оролцогчдын онцлог шинж чанар:
78 хувь хүн, оролцогч



Хөдөлгөөний 7 онцлог шинж чанар буюу хөдөлгөөний чадавхийн үзүүлэлт тус бүрээр хэрхэн үнэлснийг хураангуй байдлаар танилцуулж байна. Үүнд:

- Хөдөлгөөний нэгдүгээр шинж чанар болох олон нийтэд түшиглэсэн, олон янзын төлөөллийг багтаасан байдлыг үзүүлэлт тус бүрээр хэрхэн үнэлснийг дүгнэж харвал оролцогчид ерөнхийдөө давуу тал гэж үзсэн байна. Хөдөлгөөний гишүүд нь нийгмийн олон янзын бүлгийн төлөөлөл болж буй байдал (давуу тал: 67%), Шийдвэрлэх гэж буй асуудалд өртсөн хүн

амын төлөөллийг оролцуулсан байдал (давуу тал: 58%), Хөдөлгөөний үйл ажиллагааг дэмжигчдийн цар хүрээ (давуу тал: 64%), Хувь хүн хөдөлгөөнд гишүүн болох боломж (давуу тал: 76%), Асуудалд өртсөн олон нийтийн манлайлалд түшиглэсэн байдал (давуу тал: 70%) гэж үзүүлэлт тус бүрийг үнэлсэн байна. Үүнээс харвал энэхүү хөдөлгөөний хувьд гишүүд оролцогчид нь ч, асуудалд өртөөд байгаа бүлгийн төлөөлөл нь ч тэр хөдөлгөөнд элсэх бүрэн боломтой, асуудлаа олон талаар, бодит байдалд нийцэхүйц харж, шийдвэрлэх чадавхтай гэдэг нь харагдаж байна.


- **Олон талт манлайллын шинж чанарыг үзүүлэлт** тус бүрээр авч үзвэл, **Залуу манлайлагчдын оролцоо, хувь нэмрийг нийт оролцогчдын 65% нь сул тал**, Манлайлагчдын олон янз байдал, нийгмийн олон бүлгийн төлөөллийг багтаасан байдлыг оролцогчдын 58% хувь нь сул тал, 42% нь давуу тал, Шинэ манлайлагчид, асуудалд өртсөн хүн амын төлөөлөл, бүлгийн манлайлагчийг, 71% нь сул тал, Гишүүндийнхээ хэрэгцээнд нийцсэн манлайллыг, 54% нь давуу тал гэж үздэгээ илэрхийлжээ. Энэхүү мэдээллээс харахад **хөдөлгөөний олон талт манлайлал, орхигдсон бүлгийн манлайлалд гүйцэтгэх үүрэг, залуучуудын төлөөлөл харьцангуй сул, хөдөлгөөний хувьд зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэг болж байна** гэж үзэж болох юм.
- **Гуравдугаар шинж чанар болох дотоод болон гадаад хамтын ажиллагааг, оролцогчид ерөнхийдөө давуу талаа** гэж үзсэн байна. Харин **хөдөлгөөн доторх бүлгүүд нийгмийн шударга ёс, хүний эрхийн асуудлуудыг хангах тал дээр идэвхтэй оролцох гэсэн үзүүлэлтийг сул тал, бэрхшээл** гэж үзсэн байна. Тиймээс цаашид, хөдөлгөөний доторх асуудлаар, ажилладаг салбараараа гэх мэт нэгдсэн бүлгүүдийг идэвхжүүлэх, хамтын ажиллагааг нь сайжруулах, хөдөлгөөний нэгдсэн зорилгын хүрээнд шударга ёс бий болгох, хүний эрхийг хангахад илүү оролцуулах үйл ажиллагаа түлхүү явуулах хэрэгтэй гэж харагдаж байна.
- **Хөдөлгөөний нэгдмэл, нэг алсын хараа бүхий зорилго, зорилтыг өөрсдийн давуу талаа** гэж үздэг байна. Хөдөлгөөний оролцогч талууд, зорилго, үйл ажиллагаа, стратегиа бүрэн мэдэж, нэгдсэн нэгдмэл ойлголттой байх нь хамтын ажиллагаа, асуудлаа тодорхойлох, стратегиа төлөвлөх, чадавхиа сайжруулах гэх мэт олон асуудалд маш чухал ач холбогдолтой юм.
- **Олон төрлийн стратеги, үйл ажиллагаа явуулах хөдөлгөөний шинж чанарыг ерөнхийдөө өөрсдийн давуу тал** гэж оролцогч талууд үзсэн байна.
- **Системийн буюу хөдөлгөөний бүтцийн түвшний асуудлуудыг гишүүд**

өөрсдийн давуу тал гэж үзсэн байна. Энэхүү хөдөлгөөн нь нэг нэгнээсээ суралцах боломж, мэдлэг туршлагатай хүмүүсийг хөдөлгөөндөө элсүүлсэн байдал, шийдвэр гаргах үр дүнтэй, тогтсон механизмтай, ил тод байна гэж гишүүд үзжээ.


- 7-р онцлог шинж чанар буюу **Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, тэдний аюулгүй байдлыг гишүүд хөдөлгөөний сул тал** гэж үзсэн. Үзүүлэлт тус бүрээр харвал, Албан ба албан бус хамгааллын тогтолцоог нийт оролцогчдын 74% нь сул тал, Бие махбодийн аюулгүй байдлыг хангах стратеги, төлөвлөгөөтэй эсэхийг 76% нь, Цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах стратеги төлөвлөгөөг 80% нь, Ерөнхий стратеги, төлөвлөгөөг 80% нь тус бүр сул тал гэж үзжээ. **Үүнээс харахад, хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагчдын асуудал орхигдсон, тэдэнд аюул учирсан тохиолдолд авах арга хэмжээ нь тодорхойгүй, аюулгүй байдлаа хангах стратеги, төлөвлөгөө, үйл ажиллагаа байхгүй байна гэдэг нь харагдаж байна.**

Хөдөлгөөний гишүүд өөрсдийн хөдөлгөөнийг хөгжлийн дараах үе шатандаа явж байна гэж үзсэн байна. Үүнд 4% нь үүсэн бий болж байгаа, 46% нь бүрэлдэн тогтож байгаа, 47% нь бүрэн төлөвшсөн, 3% нь зогсонги байдалд орсон эсвэл уналтанд орсон хөдөлгөөн гэж үзжээ. Үүнээс харахад **хөдөлгөөн маань цаашид идэвхжих, илүү нягт зохион байгуулалтанд орох, илүү өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой өсөж, дэвшиж буй хөдөлгөөн** гэж үзэж болохоор байна.

Үр дүн: Манай хөдөлгөөн хөгжлийн аль үе шатандаа явж байна вэ?



Үр дүн: Давуу талаа санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн байдал:



Үр дүн: Нэн тэргүүний анхаарах асуудлууд


	Нэн тэргүүнд тавигдах асуудлууд Оролцогчдын хувиар
Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг амтаараа хангах чадвар	65%
Орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг	33%
Олон талт манлайлал	21%
Хэд хэдэн стратеги	18%
Суурь бүтэц, ситемийн дэмжлэг	17%
Нягт хамтран ажилладаг	13%
Хамтаараа улс төр, нийгмийн нийтлэг - тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн	13%

Хариултуудыг эрэмбэлсэн үр дүн:


Энэ хэсэгт асуултын боломжит хариулт тус бүрийг оролцогчид хэрхэн эрэмбэлсэн талаарх үр дүнг нэгтгэн харуулав. Үр дүнд дүн шинжилгээ хийхдээ, хариултуудыг дараах 3 ангилалд хуваан авч үзлээ.

- **Давуу тал:** Оролцогчдын хх% нь “маш их”, “Ихэвчлэн” гэж хариулсан байна
- **Бэрхшээл:** Оролцогчдын хх% нь “бага зэрэг”, “огтхон ч үгүй”, “тодорхой хэмжээнд” гэж хариулсан байна
- **Мэдэхгүй:** Оролцогчдын хх% нь “мэдэхгүй” гэж хариулсан байна


Хүчтэй, тогтвортой, олон талт, олон нийтэд түшиглэсэн байдал (орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг)



Олон талт манлайлал дараагийн үеийн манлайлагчдыг оролцуулан




Хөдөлгөөн дотроо болон бусад хамтрагч хөдөлгөөнүүдтэйгээ маш сайн хамтын ажиллагатай




Нэгдмэл зорилготойгоор улс төр нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн




Бүгд нэгдсэн ойлголттой хэрэгжүүлэх, хэд хэдэн стратегийг ашигладаг байдал



Хөдөлгөөн нь байгууллага болон системийн суурь үндсэн бүтцийг маш сайн дэмжиж байдаг



Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хамгаалагчид болон тэдний байгууллагын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадавх сайн



НИЙТЛЭГ ДАВУУ ТАЛ:

1. Орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг, 1.4: Хувь хүмүүст, энэхүү хөдөлгөөнд нэгдэж орох маш олон янзын боломжууд бий. (76%)
2. Хамтаараа улс төр, нийгмийн нийтлэг - тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, 4.3: Тулгамдаж буй асуудлын талаар нэгдмэл ойлголттой. (72%)
3. Хамтаараа улс төр, нийгмийн нийтлэг - тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, 4.5: Боломж гарч ирсэн үед, энэхүү хөдөлгөөний гишүүд маш богино хугацаанд, өндөр зохион байгуулалттайгаар хариу үйлдэл үзүүлдэг. (72%)
4. Орон нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн, иргэдтэй тулж ажилладаг, 1.5: Тухайн асуудалд хамгийн их өртсөн хүмүүс өөрсдийнхөө төлөө дуугарч, орон нутагтаа бусдыгаа манлайлж, энэхүү өөрчлөлтийн үйл явцыг өөриймсгөөр авч үздэг өөрчлөлт авчрахыг зорьж байдаг. (70%)
5. Хамтаараа улс төр, нийгмийн нийтлэг - тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, 4.4: Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжит шийдлүүдийн талаар нэгдмэл ойлголттой. (68%)

НИЙТЛЭГ БЭРХШЭЭЛ

1. Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадвар, 7.4: Манай (миний харъяалагддаг) БҮЛЭГ, СҮЛЖЭЭ, ЭВСЭЛ гишүүдийнхээ аюулгүй байдлыг хангах, сайн сайхан байдалд нь анхаарах төлөвлөгөө, стратегитэй. (80%)
2. Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадвар, 7.3: Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ дижитал (тоон системийн) аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй. (80%)
3. Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадвар, 7.2: Манай (миний харъяалагддаг) бүлэг эсвэл сүлжээ нь, гишүүдийнхээ бие махбодийн аюулгүй байдлыг хангах стратеги болон төлөвлөгөөтэй (олон нийтийн газар, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үеэр, ажлын байран дээр, гэртээ гэх мэт). (76%)
4. Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадвар, 7.1: Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хамгаалагчдын хүний эрхийн зөрчигдсөн үед нэн даруй, зохистой арга хэмжээ авч чадахуйц албан болон аблан бус бүлэг, сүлжээнүүд манай хөдөлгөөнд байдаг. (74%)
5. Олон талт манлайлал, 2.3: Шинэ үеийн болон тухайн асуудалд хамгийн их өртсөн орон нутгийн манлайлагчдыг оролцуулан, шинэ манлайлагчдыг бэлтгэх, хөгжүүлэх, дэмжих тодорхой механизм байдаг. (71%)

НЭН ТЭРГҮҮНИЙ ЧУХАЛ АСУУДАЛ : ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМТААРАА ХАНГАХ ЧАДВАР

Энэ нь яагаад бэрхшээл болж байна вэ?:	Бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх вэ?:
<ul style="list-style-type: none">• “энэ талаар ямар ч ойлголт мэдээлэлгүй байдаг. яг эрх хамгаалагчдыг хамгаалах орчин бүрдээгүй”• “Идэвхитэй манлайлагчдыг хамгаалж чадахгүй байгаа нь бусдыг идэвхитэй байлгаж чадахгүй байна.”• “Миний хувьд энэ судалгаанд оролцох явцдаа хүний эрх хамгаалагчдын эрхийг хамгаалдаг нөхцөл орчин бүрдээгүй гэж бодоход хүрлээ. үүнийг анхаарч ажиллахад дэмжлэг үзүүлнэ.”	<ul style="list-style-type: none">• “Нам улс төрийн гэдэг эрх ашгаас бус эх орон, орон нутаг, ард иргэд гэж ойлгож ажиллахад нөлөөллийн ажил хийх боломжтой. Эрх хамгаалагчдын эрх зүйн орчинг бүрдүүлэхэд олон нийтийн саналыг цуглуулах ажлыг зохион байгуулах боломжтой• “Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хуультай болгоход нөлөөлнө Олон улсын гэрээ хэлэлцээр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьна.”• “Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалагчдыг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаанд хамрагдаж, сургагч багшийн хэмжээнд ажиллах.”

НЭН ТЭРГҮҮНИЙ ЧУХАЛ АСУУДАЛ : ОРОН НУТГИЙН ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ТҮШИГЛЭСЭН, ИРГЭДТЭЙ ТУЛЖ АЖИЛЛАДАГ


<p>Оролцогчид давуу талаа хэрхэн тодорхойлсон бэ?:</p>	<p>Хөдөлгөөний үйл ажиллагаанд залуучуудын оролцоог бий болгоход тулгарч буй бэрхшээл:</p>
<ul style="list-style-type: none">• “Иргэд олон нийтэд сургалт мэдээлэл сайн өгдөг.”• “Хөдөлгөөн нь иргэдтэй тулж ажилладаг. Тэдний ойлголт хандлагыг нэмэгдүүлэхэд төрийн их ачааг үүрэлцэж яваа гэж боддог”• “Хөдөлгөөний гишүүд сургалтад байнга хамрагдан олон хүнд хүрч чаддаг”	<ul style="list-style-type: none">• “Олон нийтэд мэдээлэл хүргэх, тэднийг татан оролцуулах, олон нийт аливаа үйл ажиллагаанд оролцоо идэвх сул байдаг.”• “Залуучуудын оролцоо сул, идэвхижүүлэх.”• “Ахмад настнууд их оролцдог. залуучуудын идэвх оролцоо сул байгаа.”

БЭРХШЭЭЛ: ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО, МАНЛАЙЛАЛ

Чадварлаг, хүчтэй эмэгтэй манлайлал бий хэдий ч залуу манлайлал дутмаг

1. “Энэ сүлжээний байгууллагуудыг манлайлагч эмэгтэйчүүд удирддаг боловч манлайлагч залуучуудыг оролцуулж чадахгүй байгаа нь сул.”
2. “Төрийн албаны залгамж холбоо муу. Чадваржсан гишүүд маш их солигддог”
3. “Одоо манлайлагчид байгаа хэдий ч залуу үеийг бэлтгэх тал дээр бодлогоор дэмжих шаардлагатай.”
4. “Яг залуу манлайлагчдыг дэмжин ажилласан нь ховор. цаашид анхаарах.”
5. “Одоогоор шинэ залуу манлайлагчдын ойлголт хандлагын түвшин төдийлөн сайн биш.”

ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЕ ШАТ: ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЖИЛЭЭР



ХӨДӨЛГӨӨНИЙ НЭН ТЭРГҮҮНИЙ АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ АСУУДЛУУД: ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЖИЛЭЭР

Хөдөлгөөний үйл ажиллагаанд 0-4 жил оролцож байгаа	Хөдөлгөөний үйл ажиллагаанд 5-9 жил оролцож байгаа	Хөдөлгөөний үйл ажиллагаанд 10 болон түүнээс дээш жил оролцож байгаа
Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадвар(68%) Олон талт манлайлал (35%)	Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадвар (50%) Хамтаараа улс төр, нийгмийн нийтлэг - тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн (44%)	Хүний эрхийн хамгаалагчдын аюулгүй байдлыг хамтаараа хангах чадвар (75%) Суурь бүтэц, ситемийн дэмжлэг (30%) Олон талт манлайлал (30%)

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ХИЙГДСЭН АЖИЛ:

Хөдөлгөөний чадавхийн үнэлгээнээс, сонгож авсан хөдөлгөөний хувьд хөдөлгөөн доторх залуучуудын манлайлал болон оролцоо дутмаг, олон талын төлөөллийг багтаасан манлайлал сул байдаг, хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдалтай холбоотой асуудал орхигдсон байдаг гэсэн үр дүн гарсан. Тиймээс хөдөлгөөнийг бэхжүүлэх, чадавхийг сайжруулах зорилгоор МОНЭС болон хөдөлгөөний оролцогч талууд, манлайлагчидтай хамтран дараах зорилгод чиглэсэн үйл ажиллагаануудыг төлөвлөн, 2019 оны 11 сараас 2020 оны 8 сарыг хүртэл хийж, хэрэгжүүлсэн.

- Хөдөлгөөн доторх залуучууд, охид, залуу эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх, тэднийг идэвхжүүлэх (Дорнод аймгийн залуу охидын манлайллын хөтөлбөр гэх мэт);
- Хүний эрхийг хамгаалагчдын аюулгүй байдал, хамгааллыг хөдөлгөөн дотроо таниулах, ач холбогдлыг нь ойлгуулах, аюулгүй байдлыг хангах практик арга хэмжээ төлөвлөх;
- Хүний эрхийг хамгаалагчдын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, сургалт, хэлэлцүүлгүүд Дорнод аймгийн иргэний нийгмийн байгууллагууд, хөдөлгөөний гишүүдийн дунд зохион байгуулах;
- Хөдөлгөөн доторх олон талт манлайлал, залуучууд, асуудалд өртөж буй бүлгийн төлөөллийг оролцоог нэмэгдүүлэх, манлайлах ур чадварыг сайжруулах зорилгоор Дорнод аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Дэд Хөтөлбөр”-ийн дунд хугацааны үнэлгээг олон бүлгийн төлөөлөл, оролцогч талуудтай хамтран зохион байгуулах.

СУРГАМЖ, БЭРХШЭЭЛ:

- Үнэлгээ хийх бэлтгэл ажил, бичиг баримт, судалгааны аргачлалтай танилцах явцдаа МОНЭС-гийн тэтгэлэг олгох хөтөлбөрийн ажилтнууд нийгмийн хөдөлгөөний талаар цогц, нэгдсэн ойлголттой болж, хөдөлгөөний мөн чанар, систем, гишүүд хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагааны ач холбогдлыг ойлгож мэдсэн. Хөдөлгөөнийг нилээн хумигдмал, явцуу хүрээнд тодорхойлж байсан бидний ойлголт, мэдлэг өөрчлөгдсөн. Мөн МОНЭС-гийн хамтран ажиллагч, тэтгэлэг авагч байгууллагууд, Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хөдөлгөөний гишүүд, оролцогчдод хөдөлгөөний талаар мэдээлэл өгөх, хөдөлгөөний чадавхийн үнэлгээний аргачлалыг танилцуулах, турших боломж олгох гэх мэт үйл ажиллагаа явуулах нь чухал хэрэгцээтэй гэдгийг ойлгосон.
- Хөдөлгөөн нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, газар зүйн байршлын хувьд Улаанбаатар хотоос хол хэдий ч, хөдөлгөөнийг анх санаачлан эхлүүлсэн, манлайлагчид орон нутгийн зохицуулагчаар ажилласан нь цаг хугацаа алдалгүйгээр мэдээлэл хүргэх, үйл ажиллагаагаа төлөвлөх, тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэх, шийдвэр гаргах, оролцоог хангах гэх мэт бэлтгэл ажлыг хангахад маш чухал ач холбогдолтой байсан.
- Бид мэдээлэл цуглуулахаасаа өмнө, хөдөлгөөний манлайлагч гишүүд, ТББ-уудын зүгээс мэдээлэл, дата авах, үйл явц, оролцогчдын жагсаалтыг гаргах, асуудал, салбарыг нь тодорхойлох, ажлын байр, мэргэшлээр нь бүлэглэх гэх мэт ажлуудыг хийсэн бөгөөд хөдөлгөөний стратегийг цаг хугацааны дарааллаар нь, гишүүдийн оролцоо, бусад гадаад дотоод нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, зураглал (mapping) гаргасан нь энэ хөдөлгөөний мөн чанар, динамикийг ойлгох, үнэлгээний аргачлалаа тайлбарлах, мэдээлэл өгөхөд нэмэр тус үзүүлсэн.
-

